

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-43

1. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 28 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох /“Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын талаар/	3-43
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
10 дугаар сарын 10-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл;

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, Д.Батлут, Г.Ганболд.

Нэг. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 28 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох /“Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Х.Мөнхжаргал, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, Захиргаа, удирдлагын газрын дарга Н.Анун, Уул уурхай, технологийн газрын дарга Ч.Алтанбагана, Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од, Маркетинг, борлуулалтын хэлтсийн дарга Б.Серикжан, Ерөнхий нягтлан бодогч Ш.Цогзолмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

“Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 28 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын талаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат нар тус тус танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ж.Батжаргал, Т.Аубакир, Г.Амартүвшин, С.Ганбаатар, Н.Наранбаатар, Ц.Туваан, Ч.Ундрэм, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, мөн компанийн Уул уурхай, технологийн газрын дарга Ч.Алтанбагана нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Н.Наранбаатар, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Энхтүвшин нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 28 дугаар тогтоолын хэрэгжилт болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын талаар мэдээлэл сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 40 минут үргэлжилж, 17 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж 64.8 хувийн ирцтэйгээр 12 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Т.ЭНХТҮВШИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 9 цаг 25 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Т.Энхтүвшин: Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ өдрийн мэндийг хүргэж байна. Хуралдааны үйл ажиллагаагаар 1 асуудал хэлэлцэнэ. Хуралдаанд оролцож байгаа Байнгын хорооны гишүүдээ танилцуулъя.

Аубакир гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Раднаасэд гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн, Төмөртогоогийн Энхтүвшин гэсэн гишүүд ирсэн байна. Гишүүдийн ирц 52,9 хувьд хүрсэн учир хуралдаанаа эхлүүлъя ээ.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

“Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 28 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсох байж байгаа.

Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 28 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” компанид тогтоосон онц дэглэмийн хугацааг сунгасны дагуу “Эрдэнэс Тавантолгой” компанид тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээллийг Монгол Улсын Эдийн

засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсохоор байж байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг та бүхэндээ танилцуулъя. Монгол Улсын сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгч, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, “Эрдэнэс Тавантолгой” компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Х.Мөнхжаргал, “Эрдэнэс Тавантолгой” компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, “Эрдэнэс Тавантолгой” компанийн Захиргаа удирдлагын газрын дарга Н.Анужин, “Эрдэнэс Тавантолгой” компанийн Уул уурхай, технологийн газрын дарга Ч.Алтанбагана, “Эрдэнэс Тавантолгой” компанийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу, “Эрдэнэс Тавантолгой” компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, “Эрдэнэс Тавантолгой” компанийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од, “Эрдэнэс Тавантолгой” компанийн Маркетинг борлуулалтын хэлтсийн дарга Б.Серикжан, “Эрдэнэс Тавантолгой” компанийн Ерөнхий нягтлан бодогч Ш.Цогзолмаа нар хүрэлцэн ирсэн байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113.1-д хуульд заасны дагуу эс үгүй бол Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өөрийн санаачилгаар Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагын болон бусад байгууллагын мэдээллийг хуралдаанаар хэлэлцэж болно гэж заасны дагуу “Эрдэнэс Тавантолгой” компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсоно. Мэдээллийг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танилцуулна. Хүрэлбаатар сайдын микрофоныг нээж өгөөрэй.

Ч.Хүрэлбаатар: Эрхэм хүндэт Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 28 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” компанид тогтоосон онцгой дэглэмийн хугацааг 6 сараар сунгасан билээ. Онцгой дэглэмийн хугацаанд “Эрдэнэс Тавантолгой” компани нь нүүрсээ хил нөхцөлөөр биржээр борлуулах, санхүүгийн сахилга батыг сайжруулах, төсвийн хэмнэлт гаргах, өр төлбөрийг бууруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих том төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлсэн болно.

Түүнчлэн “Эрдэнэс Тавантолгой” компани нь нүүрс олборлолт, тээвэрлэлт, борлуулалтын үйл ажиллагааг идэвхжүүлэн Монгол Улсын экспортыг нэмэгдүүлэх, гадаад валютын нөөцийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсан болно.

Тодруулбал онцгой дэглэмийн хугацаанд нүүрс олборлолтыг 3 дахин, нүүрс тээврийг 3,5 дахин, нүүрс борлуулалтыг 3,8 дахин нэмэгдүүлсэн болно. Улсын Их Хурал, Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” компани нь биржийн арилжааг тогтмол зохион байгуулж, нүүрсээ өрсөлдөөн оруулан үнэ хүргэн зарах үйл ажиллагааг хэвшүүлсэн болно.

Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэдний тав тухтай амрах, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулсан. Энэ хүрээнд ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлсийг ажлын үр дүнтэй уялдуулан нэмэгдүүлж, уурхайчдын ая тухтай амрах “Эрдэнэс” хотхоныг ашиглалтад оруулжээ.

Ингэснээр онцгой дэглэмийн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “Эрдэнэс Тавантолгой” компанийн Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ганбат танилцуулах болно.

Анхаарал тавьсан та бүгдэд баярлалаа.

Т.Энхтүвшин: Хүрэлбаатар сайдад баярлалаа. Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгөөрэй. Ганбат дарга үргэлжлүүлээд танилцуулах уу.

Ж.Ганбат: Улсын Их Хурлын гишүүддээ өглөөний амар амгаланг айлтгая.

“Эрдэнэс Тавантолгой” компани дээр өнгөрсөн 2022 оны 10 сарын 26-наас онцгой дэглэм тогтоосноос хойш 2023 оны 9 сарын 30-ны өдрийн байдлаар үйл ажиллагааны тайланг танилцуулъя. Нийт яг 2023 оны 9 сарын 30-ны байдлаар Монгол Улс нийтдээ 48,9 сая тонн нүүрс экспорт гаргаад байна. Үүний 42 хувь буюу 20,6 сая тонн нүүрсийг нь “Эрдэнэс Тавантолгой” компани дангаараа экспорт гаргасан байна. Нийтдээ Монгол Улсын татварын орлого нь 2023 оны 8 сарын 31-ний байдлаар 14,3 их наядын татвар байгаагаас үүнээс “Эрдэнэс Тавантолгой” компани 12,4 хувь буюу 1,8 их наяд төгрөгийн татварыг энэ хугацаанд улс болон орон нутгийн төсөвт төлсөн байна.

Улсын Их Хурлаас онцгой дэглэмийг сунгахтай холбогдуулан бид нар мөн Улсын Их Хурлаар батлагдсан биржийн хууль батлагдсантай холбогдуулан нүүрсийг хил нөхцөлөөр биржээ борлуулдаг болсон. Энэ оны 2 сараас эхэлсэн. Мөн бид биржээр борлуулсан нүүрсийг Ганцмод боомт хүртэлх тээврийг “Эрдэнэс Тавантолгой” компани хариуцсан. Бид нар хил нөхцөлөөр буюу Ганцмод боомт

дээр хүргэж өгөх ажлыг зохион байгуулсан.

Төрийн нууцын зэрэглэлтэй гэрээг бүгдийг нь ил болгосон байгаа. Том худалдан авагч компаниудаас урьдчилж авсан өр төлбөрийг нийтдээ 603 сая ам.доллар байсан. Үүнийг бүрэн төлж барагдуулж ажилласан байгаа. Санхүүгийн сахилга батыг сайжруулж төсвийг хэмнэж ажилласан. Мөн “Эрдэнэс Тавантолгой” компанийн бондын 1, 2 дугаар транчийг энэ онд бид нар 4 сар, 8 сард амжилттай төлж барагдуулж ажилласан байгаа.

Компанийн үндсэн үзүүлэлтүүдийн хувьд онцгой дэглэмийн хугацаанд нийтдээ 23,7 сая тонн нүүрс олборлож, 29,5 сая тонн нүүрс борлуулан, 2,9 тэрбум долларын орлого олж, төсөвт 2,7 их наяд төгрөгийн татварыг төлсөн байгаа. Энэ бол 2022 оны 10 сарын 26-аас энэ оны 9 сарын 30-ыг хүртэлх хугацаагаар авсан байгаа.

“Эрдэнэс Тавантолгой” компани бол нийтдээ 12 жилийн түүхтэй компани. Компанийн түүхийн 12 жилийн нийт хугацааны олборлолтын 21 хувийг онцгой дэглэмийн 11 сарын хугацаанд гүйцэтгэсэн байгаа. Тэгээд онцгой дэглэмийн хугацаанд 23,7 сая тонн нүүрсийг бид олборлосон байгаа. Борлуулалтын хувьд бид нар 12 жилийн түүхийн хугацаанд бол яг бид хамгийн оргил буюу 26 хувийг онцгой дэглэмийн 11 сарын хугацаанд борлуулалтыг хийсэн. Энэ 11 сарын хугацаанд бол 29,5 сая тонн нүүрсийг бид борлуулсан. Борлуулалт 7,6 тэрбум ам.долларын орлогыг олсон байгаа. Нийт 12 жилийн хугацаа. Үүнээсээ 2,9 тэрбум ам.долларыг нь бол онцгой дэглэмийн хугацаанд олсон байгаа.

Онцгой дэглэм тогтоосон хугацаанд “Эрдэнэс Тавантолгой” компани нийтдээ 2,7 их наядын татварыг энэ хугацаанд төлж, улс болон

орон нутгийн төсөвт төлсөн ийм үр дүнтэй ажилласан байгаа.

Нүүрс борлуулалтын үйл ажиллагааны талаар танилцуулъя. Энэ онд биржийн хуулийг нөгөө Улсын Их Хурлаар батлагдсантай холбоотой “Эрдэнэс Тавантолгой” компани Монголын Хөрөнгийн биржээр нийтдээ 50 удаагийн арилжааг амжилттай зохион байгуулж, 726,9 сая ам.долларын үнэлгээтэй, 5,9 сая тонн нүүрсийг арилжсан. Үүнээс бид нар 278,6 сая ам.долларын нэмэлт орлого олсон. Бид бол бирж дээр аль болох “Эрдэнэс Тавантолгой” компани нүүрсийг сорчлохгүйгээр олборлож байгаа нүүрснүүдээ жигд борлуулах нь зүйтэй гэдэг ийм байр суурийг баримтлаад нийт 5,9 саяасаа 2,8 сая тонныг нь коксжих нүүрсийг бид нар Ганцмод боомтоор өгсөн. Үүнийг ам нөхцөлөөр 100-115 доллароор зардаг байсныг бид нар 119-182 ам.доллароор ингэж хил нөхцөлөөр зарсан. 55 хувиар нийтдээ нэмэгдүүлж зарсан байгаа. Мөн 531,2 мянган тонн эрчим хүчний нүүрсийг бид бас Ганцмод нөхцөлөөр ингээд зарсан. Энэ дээр яах вэ, 2020 онд 9 ам.доллар зарж байсан бид 8 дахин нэмэгдүүлж, 58,7-73,3 ам.доллар хүргэж биржээр арилжсан байгаа.

Дараагийнх нь бид нар 2,6 сая тонн нүүрс сул коксожсон нүүрсийг мөн зарсан. Энэ өнгөрсөн 12 жилийн хугацаанд сул коксожсон нүүрс гэдэг нь 1/3 нь коксожсон энэ нүүрсийг 212 мянган тонныг борлуулж байсан бол сая онцгой дэглэмийн хугацаанд бид 2,6 сая тонн сул коксожсон нүүрсийг амжилттай зарсан. Нийтдээ 50 удаагийн арилжаагаар. Ингээд сорчлохгүйгээр жигд борлуулах байдлаар бирж дээр арилжааг нийтдээ энэ оны 9 сарын 30-ны байдлаар 50 удаагийн арилжаа амжилттай зохион байгуулсан. Одоо бол биржийн арилжаа ерөнхийдөө идэвхэжчихсэн, жигдрээд явж байна гэдгийг хэлж байна.

Уурхайн ам нөхцөлтэй гэрээг яг 10 сарын 26-нд онцгой дэглэм тогтоогдох үед бол ам нөхцөлтэй 178 борлуулалтын гэрээ байсан. 178 борлуулалтын гэрээнээс яг ам нөхцөлтэй 133 гэрээ байсан. Гашуунсухайт нөхцөлтэй 7 гэрээ, оффтейк гэрээ 4 байсан. Энэ 4 гэрээ дотроо 38 дэд гэрээнд хуваагдаж байсан. Үүнийг бол бид яг өнөөдрийн энэ оны 9 сарын 30-ний байдлаар 178 гэрээг бид 14 борлуулалтын гэрээ байгаа. Үүнээс ам нөхцөлтэй 11 гэрээ байгаа. Гашуун сухайт нөхцөлтэй гэрээ бол байхгүй. Оффтейк гэрээ 4 гэрээ, доороо 38 гэрээ байсныг нь 3 гэрээ, 3 дэд гэрээтэй ингэсэн байгаа. Ийм байдалтайгаар бууруулсан байдлаар явж байгаа.

Бид бусдыг нь бүгдийг нь биржээр арилжаалах, үлдсэн ам нөхцөлтэй 11 гэрээний хугацаа дуусах бол ингээд дуусгавар болгоод, цаашидаа бид ам нөхцөлтэй гэрээ дахиж байгуулахгүй гэдэг ийм байр суурьтай ажиллаж байгаа.

Мөн үүнээс гадна нөгөө оффтейк гэрээ гээд байгаа. Энэ дээр бол 4 нөгөө төсөлтэй сая өмнө дурдагдсан оффтейк гэрээг 4 төсөлтэй холбоотой 38 дэд гэрээ байсан. Тавантолгой Гашуунсухайт төмөр зам дээр 27 гэрээ, Богд хаан төмөр зам дээр 9 гэрээ, нүүрс баяжуулах үйлдвэр дээр 1 гэрээ, газрын тосны үйлдвэрийн 1 гэрээ гэдэг ийм байдлаар үзсэн Шинээр бол ямар нэгэн оффтейк гэрээ онцгой дэглэмийн хугацаанд байгуулаагүй.

2023 оны 9 сарын 30-ны байдлаар яг 4 төсөлтэй холбоотой 38 гэдэг нь 3 төсөлтэй холбоотой холбоотой Тавантолгой Гашуунсухайт төмөр зам дээр 1 гэрээ өгөөд явж байна. Нүүрс баяжуулах үйлдвэр 1 гэрээ, Газрын тосны үйлдвэр дээр 1 гэрээ бол одоо хэрэгжээд явж байна. Тэгээд 2023 оны 3 сарын 31-нд хугацаа нь дуусах 26 гэрээ дуусгавар болсон. Үлдсэн 1 гэрээний хугацаа нь 2024 оны 12 сарын 31-нд

дуусгавар болно. Төмөр замын үлдэгдэл санхүүжилтийг бол энэ үлдсэн 1 гэрээгээр бүрэн төлж барагдуулах бололцоотой юм. Богд хаан төмөр замын гэрээг бүрэн зогсоосон байдалтайгаар ингэж ажиллалаа. Хил нөхцөлтэй биржийн борлуулалт гээд бид биржээр арилжсан тэр 50 удаагийн арилжаа дээр коксжих нүүрсний үнийг 58 хувь бид нар өсгөж зарсан байгаа. Эрчим хүчний нүүрсийг 74 хувиар бид нар өсгөж зарсан. 1/3 коксжих нүүрсийг яах вэ, энэ дээр бид нар өмнө нь маш бага хэмжээтэй зарж байсан учраас энэ дээр бол нийтдээ 99,2 хувиар өмнө нь байсан нүүрсийг бид нэмж ингэж биржийн арилжааг зохион байгуулж ажилласан байгаа.

Нүүрс тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагаа байна. Тээвэрлэлтийн үйл ажиллагааг бид нар Төрийн худалдан авах ажиллагааны агентлагтай хамтран агентлаг дээрээ гол тээвэрлэлттэй холбоотой сонгон шалгаруулалтыг зарлаж байгаа. Нүүрс тээврийн зохион байгуулалтыг сайжруулж, тээврийн компанийн үйл ажиллагааг дэмжсэнээр төсөвт төлөх татварын хэмжээ нэмэгдсэн. Ерөнхий гэрээний тендер зохион байгуулалт хийсэн. Энэ дээр 10 чиглэлийн 23 багц тендер зарласан байгаа. Үүн дээр 2 удаагийн сонгон шалгаруулалтаар нийт 335 аж ахуйн нэгж оролцсон, 541 тендерийн санал ирүүлж шаардлага хангасан 185 аж ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулсан. Тэгээд тендерийн 2 дахь шатны захиалгаа бид тендерийн 2 дахь шатын шалгаруулалт дээр төрийн худалдан авах ажиллагааны газрын шалгаруулж байгаа дээр 4 чиглэлийн 7 багцад 113 компанийг шалгаруулж, нүүрс тээвэрлэх гэрээг байгуулан биржийн нүүрс тээврийг 2023 оны 3 сарын 3-ны өдрөөс эхлүүлсэн. Энэ дээр нийт төсвийн хэмнэлт нь 268,9 тэрбум төгрөг. Нийт 1 тонн тээврийн төсөвт өртөг нь 163460 төгрөг байсныг бид энэ дээр тээврийн дундаж нь 55875 төгрөгөөр бол 1 тонн нүүрсийг тээвэрлэх ийм өртөгтэйгээр байна.

Ингээд гэрээ байгуулаад тээврийн компаниудыг биржийн нүүрсийг тээвэрлүүлээд хил нөхцөл дээр ингэж явснаараа 9 сарын 30-ны байдлаар бол 2,3 сая тонн нүүрсийг хүргэж өгөөд байна. Тэгээд тээврийн компаниудын төлсөн татвар бол 2021 онд 29,2 тэрбумыг төлдөг байсан бол 2023 оны 9 сарын байдлаар 187,4 тэрбум төгрөгийг төлдөг болоод байна. Яах вэ, тээвэрлэлт дээр бид нар хилийн гарцыг биржийн нүүрсийг тусгай гарцаар гаргах асуудлыг Засгийн газрын хуралдаанаас шийдвэр гаргасан. Энэ дагуу холбогдох яамнууд “Эрдэнэс Тавантолгой” компаниудтай хамтраад ажиллаж байгаа. Бид тээврийн асуудлыг тусгай гарцаар гаргаад явуулчих юм бол биржийн арилжаа нүүрс тээврийг бид саадгүй хүргэж өгөх бүрэн бололцоотой юм аа гэдэг ийм байдлаар ажиллаж байгаа.

“С” зөвшөөрлийн олголт гээд энэ асуудлыг бол Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолоор “С” зөвшөөрлийг хэрэгжилтийн хүрээнд ачаа тээврийн хил нэвтрэх “С” төрлийн зөвшөөрлийн бичиг хүсэлт гаргаж шаардлага хангасан компаниуд ижил тэгш зарчмаар нээлттэйгээр олгож байгаа. Энэ бол Засгийн газрын шийдвэрийн дагуу өмнө нь бол Авто тээврийн Үндэсний төв олгодог байсныг компаниуд өөрсдөө олгодог болчихсон байгаа. Үүнийг бол бид *erdenestavantolgoi.mn* гэсэн компанийн цахим хуудсан дээр бүх мэдээллийг, ил тод нээлттэй байршуулаад, үүгээрээ бол мэдээллүүдээ аваад, энэ дагуу бид ил тод нээлттэйгээр “С” зөвшөөрөл олгоод байна. Яах вэ, өнөөдрийн байдлаар бид 2023 оны 3 дугаар улирлын “С” зөвшөөрлийн олголт бол нийтдээ 18700 хүсэлт ирснээс бид нар өгөх бололцоотой нь 4680 байдаг. Хувь тэнцүүлээд бид энийг ил тод нээлттэй олгох байдлаар зохион байгуулж байгаа. 2023 оны 4 дүгээр улиралд “С” зөвшөөрлийг олгох ажлыг бид ингэж зохион байгуулаад энэ 7 хоногт олгохоор байгаа. Тэгээд энэ талаар “Эрдэнэс Тавантолгой”

компанийн веб сайт дээр цахимаар нийт хүсэлт гаргасан, олгосон байдлуудаа бүгдийг нь ил тод нээлттэй мэдээлээд явж байгаа.

“Эрдэнэс Тавантолгой” компани дээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн асуудлууд байна. Засгийн газрын 2012 дугаар сарын 9-ний өдрийн 440 тогтоолын дагуу “Эрдэнэс Тавантолгой” компани төрийн нууцын зэрэглэлтэй дараах 7 гэрээг ил болгож веб сайт дээр байршуулсан байгаа. Энэ дээр Тавантолгой Гашиунсухайт чиглэлийн төмөр замын 2 гэрээ байсан. Богд хаан төмөр замын 3 гэрээ байна. Загийн усны хоолойн гүний ус гэдэг төсөл 1 гэрээ, Тавантолгойн ордын далд уурхайн хайгуул судалгааны ажил гүйцэтгэх гэрээ гээд 1 гэрээнүүд хийсэн. Эд нарыг бүгдийг нь ил болгосон. 2022 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр компанийн цахим хуудсаар дамжуулан нүүрс борлуулах 140, олборлолт ачит өрөмдлөг зэрэг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах нийт 544 гэрээг олон нийтэд ил тод болгосон байгаа. Оффтейк гэрээний дагуу олгосон /тэр ард талын хүрээнд тэр график дээр/ оффтейк гэрээний үнэ ямар байсан. Бидний биржийн харьцуулсан үнийн зөрүү нь ямархуу байсан бэ гэдгийг энд бид энэ график дээр харуулж, ийм зөрүүтэйгээр бид өөрөөр хэлбэл оффтейк гэрээ дээр хямдралтай үнээр нүүрсийг борлуулж байжээ. Ийм хэмжээний боломжийг бас бид алдаж байж гэдэг ийм байдлаар энэ график дээр харагдаж байгаа.

Дараа нь бид компанийн хувьд яг үндсэн үйл ажиллагаатай холбоотой 10 сая тонныг нойтон аргаар угаах үйлдвэр ашиглалтад оруулахаар төсөл хэрэгжээд явж байгаа. Энэ төслийн үйлдвэрийн төслийн барилга угсралтын ажлыг эрчимжүүлээд нүүрс баяжуулах үйлдвэрийн ашиглалтад орох хугацааг 2 сараар урагшлуулаад 2024 оны 5 сард үйлдвэрийг ашиглалтад оруулахаар гүйцэтгэгч компанитай шахаж

ажиллаад явж байгаа. Энэ үйлдвэр 10 сая тонны хүчин чадалтай. Ийм байдлаар энэ төсөл хэрэгжээд явж байгаа. Усан хангамжийн төсөл гээд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах Загийн усны хоолойн төсөл ашиглалтад ороход бэлэн болчихоод байгаа. Бусад хангамжийн төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа. Нүүрс баяжуулах үйлдвэрийг түүхий нүүрсээр хангах конверын системийн төслийг гүйцэтгэгч сонгон шалгаруулалтыг эхлүүлэх ажлыг зохион байгуулаад байна. Энэ бол баяжуулах үйлдвэртэйгээ уялдаад конверын системийг сонгон шалгаруулалтын зарлахаар ажиллаж байгаа. Төслүүдийн явц гээд дээр яах вэ, нийтдээ 11 төсөл байгаа. Төсөвт өртөг нь 5,2 тэрбум доллар. Үүнээс 1,8 тэрбум долларын санхүүжилтийг нь олгоод байна. Тэгээд үүнтэй холбогдуулан холбогдох мэдээллүүдийг нь дээр гаргасан байгаа. Богд Хаан төмөр замын төслийг бол бүрэн зогсоосон байгаа. Үүн дээр уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүд буюу уурхайн тоног төхөөрөмж, ил уурхайн конверын систем дээр нийтдээ 1,1 тэрбум ам.доллар, үүнээс 23,5 сая ам.долларыг нь олгосон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох төслүүдийг Нүүрс баяжуулах үйлдвэрт Загийн усны хоолой, гүний ус ашиглах, газрын тос дамжуулах хоолой, Тавантолгой дулааны станцтай холбоотой нийт төсөвт өртөг нь 1 тэрбум доллар, үүнээс 236,3 сая ам долларыг олгосон. Төмөр замын төслүүдээ Тавантолгой-Гашиун сухайт төмөр зам, Тавантолгой-Зүүнбаян төмөр зам, Тавантолгой-Гашиунсухайт, Тавантолгой-Зүүнбаян төмөр замуудыг холбох төмөр зам, Тавантолгой нүүрс ачих логистикийн төв гээд энэтэй холбогдуулаад нийтдээ 3 тэрбум ам.долларын төсөвт өртөгт олгосон 1,4 тэрбум долларыг олгосон ийм байдалтайгаар төслийн хэрэгжилт явж байна.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн талаар би гол ярьчихлаа. Энийг бол бид

аль болох л хугацаанаас нь өмнө ашиглалтад оруулахаар нэлээн шахаад ажиллаад ирэх 2024 оны 5 сард оруулахаар ажиллаж байгаа. Санхүүгийн үйл ажиллагаа төсвийг хэмнэх зорилтын хүрээнд биднийг уулын ажилд тэсэлгээ ачилт бусад гэдэг байдлаар төсвийг бууруулан зарласнаар хэмнэлт үүсгэсэн. Үүн дээр уулын ажил дээр бид нар 1м3-ын өртгийг 12945 төгрөг байсныг 11982 төгрөг болгоод, түүнээс 238,6 тэрбум төгрөг. Тэсэлгээ дээр бид нар 2 мянган төгрөгөөр нь м3-ын тэсэлгээ хийдэг байсныг 1198 төгрөгөөр м3-ыг нь болгож бууруулсан. Эндээс 123,1 тэрбум төгрөг. Ачилтыг бол тонн ачааг 1763 төгрөгөөр хийдэг байсныг 1598 төгрөг болгосон. 17 төрлийн ажлын төсвийг бууруулан зарласнаар ингээд нийтдээ төсөвт өртгүүдийг тодорхой хэмжээнд бууруулна. Мөн олборлолт хийж байгаа компаниудыг нөгөө дизель түлшний үнэтэй уялдуулан бид бас зохицуулалт хийж байгаад үнийн тохируулга хийснээрээ бол 3930 төгрөгөөр метр куб гэснийг бууруулаад 2,3 тэрбум төгрөг, мөн уулын ажлын бас хөрс хуулалтыг бууруулснаараа 3,6 тэрбум төгрөгийг энэ 2023 оныг дуусталх хугацаанд хэмнэлтийг хийсэн.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн бондыг эргэн дуудсанаар бид нар транч 4 дүгээр хэмд нь нэрлэсэн үнэ нь 76,6 тэрбум төгрөг байсан, хүү нь 17 хувь байсан. Үүний дуусах хугацаа нь 2025 оны 5 сарын 9-нд байсныг 2023-ны 9 сарын 28-нд дуудаад хүүгийн зардлыг бид нар 20,6 тэрбум төгрөгөөр хэмнэж ингэж ажилласан үр дүнтэй байгаа. Санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах гэдэг дээр яах вэ, саяынх ярьчихсан.

Ямар нэгэн байдлаар бид яах вэ олон улсын аудит бол Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийн дагуу олон улсын аудитыг оруулсан. Мүр гэж аудитын компани бол энэ дээр “Эрдэнэс Тавантолгой” компани дээр орж байгаа олон улсын аудит хийж байгаа. Төсвийг хэмнэх өр төлбөрийг бууруулах, мөнгөн

хөрөнгийг оновчтой удирдах арга хэмжээг авч байсан “Эрдэнэс Тавантолгой”-н 1, 2 транчийг 236,5 тэрбум төгрөг, 52,3 сая ам.доллар хугацаанд нь бол өөрсдөө орлогоор мөнгөн хөрөнгийнхөө хүрээнд энэ оны 4 болон 8 сард төлж барагдуулсан байгаа.

Компанийн хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдээс санхүүжилтийг өөрсдийн борлуулалтын орлогоос санхүүжүүлж, гаднын эх үүсвэр өр төлбөр огт нэмэгдүүлээгүй байдлаар ажиллаж, урьдчилж ямар нэгэн байдлаар мөнгө худалдан авагч болон гаднын компаниасаа аваагүйгээр ингэж ажилласан. Компанийн өр төлбөрийн хувьд нийт өр төлбөр өнгөрсөн оны мөн үеэс 2 их наяд төгрөгөөр буурч, 2,3 их наяд төгрөгөөр байна. 2022 оны 3 дугаар улиралд 4,3 их наядын өртэй байсан бол 2023 оны 3 дугаар улирлаар 2,3 их наядын яг өнөөдрийн байдлаар өртэй байна. Богино хугацаат өр төлбөр 65 хувиар буюу 1,7 их наяд төгрөгөөр бууруулсан. Экспорт, борлуулалт нэмэгдсээр ашигт ажиллагаа нэмэгдсэн. Жишээлбэл татварын ногдол хэсэг нэмэгдсэн байгаа. Урьдчилж орж ирсэн орлогыг 1,8 их наядаар бууруулсан. Ийм байдлаар өр төлбөрийг бууруулж ингэж ажилласан.

2023 оны яг 3 дугаар улирлын байдлаар бид 2,3 их наяд төгрөгийн өр төлбөртэй өнөөдрийн байдлаар байна.

2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангаар орлого үр дүнгийн тайлангаар компани түүхэн дэх хамгийн өндөр орлого ашигтай ажиллаж байсан. 2019 онд ковидын өмнө бол “Эрдэнэс Тавантолгой” компани хамгийн өндөр ашигтай ажиллаж байсан юм байдаг юм байна лээ. Энэ үзүүлэлтээс 3 дугаар улирлын байдлаар 2023 оны 3 дугаар улирлын тайланг 2019 оны 3 дугаар улиралтай харьцуулах юм бол 2,6 дахин өндөр цэвэр ашигтай ажилласан байгаа. Борлуулалтын нийт орлого нь 6,7 их наяд төгрөг, нийт ашиг нь 5,1 их наяд төгрөг. Татварын өмнөх цэвэр ашиг нь

3,6, тайлант үеийн цэвэр ашиг нь 2,7 их наяд төгрөгийн ашигтай ингэж ажиллалаа.

Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд ажилчдын үндсэн цалинг өнгөрсөн оны сүүлээр 40 хүртэл хувиар нэмэгдүүлсэн. Энэ бол компанийн үйлдвэрчинтэй хамтын ажиллагааны гэрээнийхээ хүрээнд 3 жил тутам 1 удаа шинэчилдэг юм байна лээ. Тэр шинэчлэх хугацаа нь өнгөрсөн 2022 оны оны сүүлээр бас шинэчлэх ажил яг давхацсан. Энэ хүрээндээ 40 хувиар нэмэгдүүлсэн. 2 дахь нь ажилчид жилийн эцэс, хагас жилд 3-6 сарын урамшуулал олгосон. Уурхайчдын 300 хүний “Эрдэнэс” хотхон гэдэг өмнө нь баригдаад явж байсан, зогсчихсон байсан. Энийг ашиглалтад оруулж хүмүүсээ энд 300 хүнийг байршуулсан байгаа. Цанхи, Цагаан хадны ажилчдын катерингийн шинэчлэл ажилчдыг эрүүл, аюулгүй орчин байдлыг бүрдүүлэхэд анхаарч ажилласан. Уурхайд засварын хүчин чадлыг нь нэмэгдүүлж засварын иж бүрдэл засварын төвийг байгуулах ажил хийгдэж байна. Цанхи, Цагаан хадны ажилтны катерингийн шинэжтэй аюулгүй байдлыг нь хангаж, нийгмийн асуудал дээр бол онцгой байдалд анхаарч ажилласан.

Бусад асуудлын хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” компани Таван толгой түлш гэдэг компанийг ингээд бүрэн санхүүжүүлж ажиллаж байгаа. Энийг 2018-2023 оны 9 сарын хугацаанд нийтдээ 981,4 тэрбум төгрөгийг Тавантолгой түлш компанид өгч байна. Мөн дотоодын цэргийн хамгаалалтад 2021 онд орсон юм байна лээ. 2021-2023 оны 9 сар хүртэл 34,7 тэрбум төгрөг өгсөн. Тэрбум модны төслийн санхүүжилт нь 2022 оноос 2023 оны 9 сар хүртэл 24,3 тэрбум төгрөг өгсөн.

Багануур Шивээ-Овоо компанид 2018 оноос эхлээд 2023 оны 9 сар хүртэл нийтдээ 61,9 тэрбум төгрөгийг зээл олгосон байгаа. Үүнийг бол зээлийн эргэн

төлөлтөд Багануур, Шивээ-Овоотой, Эрдэнэс Монголтойгоо хамтраад эргэн төлөлтийг нь төлүүлэх байдлаар ингэж ажиллаж байгаа. Орон нутгийн бүтээн байгуулалт бол 2020 оноос хойш 19,8 тэрбум төгрөг олгосон байна. Өмнөговь аймгийн Онцгой байдлын ерөнхий газар болон орон нутгийн хөгжлийг дэмжих санд 2021-2023 оны 9 сард 10,9 тэрбум төгрөгийг өгч, нийтдээ 1,1 их наяд төгрөгийг бусад санхүүжилтүүдийг олгож ажилласан юм байна.

Нүүрс тээврийн үйл ажиллагааг бол нүүрс тээврийн бүх үйл ажиллагааг ил тод цахим хуудсаараа байршуулаад, уурхайгаас ачигдсан нүүрс ачигдахаас эхлээд хил гарах хүртэлх бүх мэдээллүүд *ett.mn* гэдэг веб сайт дээр байршуулаад, энэ мэдээллийг олон нийтэд ил болгоод ингээд ажиллачихсан байгаа. Ер нь бол энэ юун дээр тээвэр болон олборлох бүхий л үйл ажиллагаануудаа *ett.mn* гэсэн веб сайтаараа бүрэн мэдээлээд, энэ веб сайтыг тогтмолжуулаад явж байгаа. Онцгой дэглэмийн хугацаанд хүрсэн үр дүнг бол ах вэ, одоо хугацаа нь 4 том худалдан авагч байгаад байгаа. Энэ дээр Чалко, Голори Таун гэдэг нь Норинко, тэгээд Жай Ю, И-ком гэсэн ийм 4 компани бол ингээд 4 том худалдан авагчаас 2021 оны 7 сараас 2022 оны 9 сар хүртэлх хугацаанд нийтдээ 606 сая ам.долларын урьдчилгааг аваад, үүнийг бас сая 2023 оны 9 сарын 12-нд хамгийн сүүлд Чолко компанийн өрийг үрэн төлж барагдуулсан. Одоо бол бидэнд урьдчилж авсан орлого юм уу, урьдчилж их хэмжээгээр авсан мөнгө байхгүй. Одоо энэ 4 компанидаа борлуулж байгаа нүүрснүүдийн төлбөр бол мөнгөөрөө 100 хувь компанид орох ийм боломжийг нь ингэж хангаж өгсөн байгаа. Яах вэ, энэ гэрээнүүдийн хугацаа бол хамгийн юу нь бол Чалко компанийн гэрээ 2027 онд дуусах юм байна лээ. Бусад нь ирэх онд энэ 15 саяар хийсэн гэрээнүүд ирэх оны 9 сард дуусчих болов уу гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

Онцгой дэглэм тогтоосны үр дүнд нийтдээ бид нар Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд бид нар Монгол Улсад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх гол үндсэн үүрэг өгчихсөн байгаа. Энэ үүргийн хүрээнд 2022 оны 4 дүгээр улиралдаа нийтдээ 588 сая ам.долларын үнэлгээтэй 6,6 сая тонн нүүрс борлуулсан. 2022 ондоо бид нар яг Монгол банканд бэлнээр 416 сая ам.доллар, урьдчилж олсон орлогоос 155,5 сая ам.долларыг бууруулсан байгаа. Нийт өнгөрсөн 2022 оны 10 сараас яг энэ оны 9 сарын 30 хүртэлх хугацаанд нийтдээ бид дансанд орсон нь 1,9 тэрбум ам.доллар орсон. Үүнээс Монгол банканд. Бид нар 1,5 тэрбум ам.долларыг нь Монгол банканд тушаасан. Ийм үр дүнтэй ажилласан байгаа.

Энэ үр дүнгүүдийг Хүрэлбаатар сайд хэлчихсэн учраас бид бол үр дүнгүүдийг онцгой дэглэмийн хугацаанд борлуулалтыг бид энэ онцгой дэглэмээс өмнөх хугацаа гэдэг нь дандаа 2019 он гээд хамгийн оргил байсан үетэй нь харьцуулж ингэж гаргасан байгаа. Борлуулалтыг 3,8 дахин, тээврийг 3,5 дахин, экспортыг 2,3 дахин, орлогыг 3 дахин, олборлолтоо 3 дахин нэмэгдүүлсэн ийм үр дүнтэй ажилласан. Онцгой дэглэм тогтоосноос хойш 2023 оны 9 дүгээр сарын 30-ыг дуустал хугацаанд 2,9 тэрбум ам.долларын үнэлгээтэй 29,5 сая тонн нүүрс борлуулсан. Нийт бусад гэрээ гээд дэнэ дээр нийтдээ компанийн 12 жилийн түүхэн дэх нийт борлуулалтын 26 хувь буюу 29,5 сая тонн нүүрсийг нь онцгой дэглэмийн 11 сарын хугацаанд бид борлуулсан. Биржээр бид нар 5,9 сая тонн нүүрс борлуулсан, үүнээс 2,3-ыг нь хүргэж өгөөд, замд явна 3,6 сая тонн нүүрс байна. Саяын би тоонуудыг дээр дурдчихсан болохоор уншихгүйгээр ингээд Монгол банканд 1,5 тэрбум ам.долларыг бид арилжсан буюу тушаасан ийм үр дүнтэй ажиллалаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Т.Энхтүвшин: Ганбат даргад баярлалаа. “Эрдэнэс Тавантолгой” компанид тогтоосонд онцгой дэглэмийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын мэдээллийг сонслоо.

Мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Туваан гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүний микрофоныг өгөөрэй.

Г.Дамдинням: Компанийн мэдээллийг сонслоо. Тэгээд хэдэн асуулт байна. Нүүрсний хулгай гээд л баахан бужигнацагасан. Энэ дээр хамгийн том хохирол юун дээр байгаа гээд байгаа юм. Оффтейк гэрээ дээр байгаа гээд байгаа юм. Тэгээд бүх оффтейк гэрээг ил гаргасан л гэж ойлгоод байгаа. Тэгээд энэ чинь үндсэндээ 38 дэд гэрээ байгаа юм шиг байна. Тэгээд “Бодь” групптэй тэгээд л төмөр зам гээд л баахан үнэтэй гэрээнүүд байгуулсан. Түрүүн та хүснэгт харуулж байна лээ. График харуулж байна лээ. Бид нар байгуулсан гэрээнээс зөрүү нь өөрөөр хэлбэл төр хэр хэмжээгээр хохирчлоод байгаа юм. Энэ чинь аягүй хямдруулаад өгчихсөн юм байна шүү дээ. Одоо яг энэ дээр харагдаж байна. 31 хувийн зөрүүтэй байх шиг байна. Тийм үү. Тэгэхээр та нар энэ дээр мөнгөн дүнгээр нь бодоод гаргачихсан хохирлын хэмжээ байгаа юу. “Эрдэнэс Тавантолгой” бодвол хууль хяналтын байгууллагууд хохирогчоор орчихсон явж байгаа байх. Энэ оффтейк гэрээнүүд дээр Монгол Улс энэ компани дээр хэр хэмжээний хохирол мөнгөн дүнгээр амсчхаад байгаа вэ. Энэ тоог мэдчихмээр байна.

2 дугаарт ашигт малтмалыг биржээр борлуулах тухай бид нар хууль гаргаад ингээд явж байгаа. Тэгээд “Эрдэнэс Тавантолгой”-н биржээр борлуулах нүүрсний хэмжээ яагаад өсөхгүй байна. Бүх нүүрсээ биржээр зарах ёстой шүү дээ уг нь. Хууль нь угаасаа тийм л байгаа. Тэгээд энэ дээр яагаад болохгүй байгааг эсвэл Их Хурлаас

хийх ёстой юм байгаа юу. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

3 дугаарт Богд хаан төмөр замын гэрээг зогсоосон гээд байх юм. Гэрээ зогсооно гэдэг чинь ямар ойлголт байдаг юм. Цуцлах эсвэл хэрэгжээд явах л байгаа шүү дээ. Тэгээд цуцалчаж болдоггүй юм уу. Зогсооно гэж юуг хэлж байгаа юм. Энэ чинь бас л нэг хулгай луйврын л юм байгаад байгаа л харагдсан шүү дээ. Тэгээд энэ дээр шууд цуцлаад явчихад юу нь болохгүй байгаад байгаа юм. Зогсооно гэж яг юу хэлээд байна та нар.

4 дүгээрт энэ тээвэр дээр их олон машин л бужигнаад л бараг хэдэн километр зогсдог тэгээд л баахан бужигнаан болдог доо. Тэгээд энэ хэвээрээ байгаа юу. Тээврийн машинуудын тоог та нар бууруулчаж болохгүй юу. Хажуухан талд нь хувийн хэвшил өөрсдөө чиргүүлтэй машинаар хэдхэн машинаар зөөгөөд болоод байгаа шүү дээ уг нь. Тэгэхээр энэ дээр та хэд маань ямар нэгэн арга хэмжээ авч байгаа юу. 8 мянган машин ч билүү хэдэн мянган машин ч билээ. Тэр бол танай хүчин чадлаас хэд дахин давчихсан л машины тоо юм байна лээ. Тэр “С” зөвшөөрлийн чинь тоо бол. Тэгээд 1 машин нь сардаа 1 юм уу 2 удаа л хил давдаг бололтой юм шиг байна лээ. Тэгээд хэвээрээ байгаа юу. Энийгээ цөөлөөд, тэгээд байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь ч гэсэн тэнд очоод зогсоод байх хүнийх нь тоо нь ч гэсэн багасах л ёстой шүү дээ. Тэгээд тэр нь тээврийн машины тоо багаслаа гээд төлөх татвар багасахгүй шүү дээ. Эргэлт нь л олон болж байвал сайн л биз. Энэ дээр бас нэг хариулт өгөөч.

Дараагийнх нь 1м3 уулын цулыг 12 мянган төгрөгөөр та нар хуулуулж байгаа юм байна. Ажиллуулж байгаа юм байна. Энэ жоохон үнэтэй л харагдаад байна даа. Өөр бууруулах боломж байгаа даа. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Төгсгөлд нь “Эрдэнэс Тавантолгой” компани дээр байнга гардаг нэг асуудал юу байдаг вэ гэхээр хөрсний сийрэгжилттэй холбоотой маргаан их явдаг юм даа. Танай маркшейдерүүд тэгээд аудитын дүгнэлтээр бүүр гарч байсан юм байна лээ шүү дээ. Нэг жилийнх нь хөрсний сийрэгжилтийн зөрүү нь бараг 50, 60 тэрбум төгрөгийн хулгай явчихсан байна гээд. Энэ дээр ямархуу өөрчлөлтүүд орсон бэ. Хяналт тавьсан уу. Ийм 5 асуулт байна.

Т.Энхтүвшин: Ганбат дарга. Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгөөрэй.

Ж.Ганбат: Асуултад хариулъя. Оффтейк гэрээтэй гээд энэ график дээр саяын харуулж байсан. Энэ дээр бол нийтдээ бид оффтейк гэрээ биржийн нүүрсний гэрээний зөрүүг нь харахаар 37 хувь, 37 хувь, зарим нь 31, 30 гаруй хувьтай ийм зөрүүтэй үнээр бид өөрөөр хэлбэл биржийн үнээс оффтейк гэрээнүүдийн өмнө ингээд явчихсан. Одоо тухайн үедээ энэ гэрээнүүд бол ингээд компани төлөөлөөд хүмүүс нь зураад энэ гэрээнүүдийн ажил бол явчихсан. Энэ ажлууд нь тухайн үедээ хийгдээд, жишээ нь Гашуунсухайт төмөр замын ажлууд ингээд дуусах шатдаа орчихсон явж байгаа. Бид бол энэ зөрүү дээрээс нь хохирол энэ тэр гэдэг юм бол бид нэхэгдээгүй. Тухайн үедээ Төлөөлөн удирдах зөвлөл болон тухайн үедээ бас Засгийн газрын түвшинд бас яригдаж байгаа зарим юунууд нь шийдвэр нь гараад хэрэгжээд явчихсан байдаг юм байна лээ. Нэгэнт ингээд Засгийн газрын бодлого гараад тухайн үеийн нөхцөл байдал ам нөхцөлтэй гэрээгээр ингээд хийгдээд явчихсан учраас бид энэ дээр ингэсэн. Зүгээр яах вэ, хэрвээ тухайн үедээ гэрээг бид нар хил нөхцөлөөр гэж хийгээд явсан бол одоо энэ дээр бид зөрүү хамгийн багадаа 30 хувийн орлого нэмж олох байжээ гэдэг ийм л дүгнэлтүүд хийж байгаа. Тэгэхээр бид энийгээ зогсоогоод, одоо дахиж цаашаа

оффтейк гэрээ гэдэг юмыг хийхгүй гэдэг ийм байр суурь дээр бол хатуу, өмнөх гэрээнүүдийг аль болох дуусгавар болгох тал руу нь нэлээн хатуу байр суурь баримтлаад ингээд ажиллаж байгаа.

Биржийн арилжаа бол энэ оны 2 сараас эхэлсэн. Эхэндээ үнэхээр бас амаргүй байсан. Одоо бол биржийн арилжаа бол идэвхэжчихсэн. Бид биржээр арилжих нүүрсний хэмжээг сая 7 сарын 1-ээс Улсын Их Хурлаар батлагдсан биржийн хуулийг албан ёсоор хэрэгжээд эхэлчихсэн. Энэ ууль хэрэгжиж эхэлснээр бид бирж дээр арилжих нүүрснийхээ хэмжээг нэмэгдүүлсэн байгаа. Нийтдээ 6 сая тонн нүүрс бид нар биржээр арилжсаны бараг 2,9 хавьцаа нь зөвхөн 7 сараас хойш энэ хуулиас хойшоо бид нар нэмэгдүүлчихсэн байгаа шүү дээ хэмжээгээ. Бид бирж дээр арилжиж байгаа нүүрснийхээ хэмжээг хамгийн багадаа 320 мянга, дээд тал нь 640 мянган тонноор арилжаад эхэлж байгаа. Ер нь тогтмол хамгийн багадаа 2 оролцогч дээд талд нь 4, 5 тэгээд дуудсан бол хамгийн оргил үедээ 40 хэдэн удаа үнэ хаялцуулаад 40 гаруй хувиар нэмэгдүүлж авсан ийм юмнууд гараад байгаа учраас биржээр ингэж байгаа. Нөгөө талдаа яг биржийн арилжаа дээр нийтдээ оролцсон арилжааны 80 гаруй хувийг нь “Эрдэнэс Тавантолгой” компани бол дангаараа биржийн арилжаа хийж байгаа. Бид бол биржийн арилжаа дээр манлайлаад хамгийн идэвхтэй байдлаар “Эрдэнэс Тавантолгой” компани ингээд ороод яваад байгаа. Нийт борлуулж байгаа нүүрсний бид яг 30 орчим хувийг нь бид нар биржээр арилжиж байгаа. Энийг бид цаашаа нэмэгдүүлэх ийм бодлого барьж байгаа. Яах вэ, тээврийн нөхцөл, хилийн нэвтрэлттэй холбогдуулан бид хүргэлтийн асуудлыг анхаарах, Засгийн газраас биржийн нүүрсийг тусгай гарцад нэвтрүүлэх ийм шийдвэр гаргачихсан учраас хүргэлт дээрээ бид нэмэгдүүлээд явчихвал биржийн арилжааг нэмэгдүүлэх ямар ч асуудалгүй. Одоо бол бирж дээр

бид ер нь биржийн арилжааг худалдан авагч талаас гадна, дотнын компаниудын зүгээс их хэмжээтэйгээр арилжиж өгөөч гэдэг захиалга бол байнга ирж байгаа. Бид тэр дээр нь яах вэ уулын ажлын нөхцөл байдалтайгаа, хил нэвтрэлтэйгээ уялдуулаад л арилжаад байгаа учраас сүүлийн үед биржийн арилжаа огцом нэмэгдээд явж байгаа.

Богд хаан төмөр замтай холбоотой 3 дахь асуудал бол “Эрдэнэс Тавантолгой” компаниас зөвхөн санхүүжүүлэх байдлаар оролцож байсан юм байна. Бусад нь бол Тавантолгой төмөр зам дээр тэр гэрээнүүд нь хийгдээд явчихсан учраас бид бол санхүүжилтийг зогсоосон. Зогсоогоод онцгой дэглэм тогтоосны дараа Тавантолгой төмөр замын дансанд 50 хэдэн тэрбум төгрөг байсныг бид нар буцаагаад татсан. Тухайн үедээ ажил эхлэх зөвшөөрөл тэрийг нь өгөгдөөгүйгээр бас ажил хийгдсэн юмнууд байсан учраас бид санхүүжилтийн дансанд нь байсан мөнгийг нь 50 хэдэн тэрбум төгрөгийг буцаад.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг 2 минутаар сунгаад өгөөрэй. Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгөөрэй.

Ж.Ганбат: Тэр тээвэртэй холбоотой дараагийн асуудал дээр ер нь ийм л юм байна лээ. Хамгийн гол зангилаа нь би шулуухан хэлэхэд Монгол Улсад нүүрс тээврийн яг ийм автомашин 20 гаруй мянга байдаг юм байна лээ. Бүртгэлтэй. 20 гаруй мянган автомашины бид хэрэгцээг нь хангасан тээврийн тийм барааг нь нүүрсийг нь өгөх тээвэрлэх боломж байхгүй юм байна лээ. Нөгөө “С” зөвшөөрөл гэдэг юм нь олгогдож байгаа 4685 ингээд яг манай компанид олгож байгаа нь тэр. Одоо яг энд ингээд хүсэлт гаргаж байгаа компаниуд нь 12, 13 мянган компани манай компаниас “С” зөвшөөрөл авъя

гээд хүсэлт гаргачхаж байгаа юм. Нөгөө талдаа бид экспортоо нэмэгдүүлээд сард сая бид нар 8, 9 сард бол “Эрдэнэс Тавантолгой” компани бол сард 3 сая тонн нүүрс бид нар экспорт гаргасан. Тэгэхэд бид энийг чинь гол юм маань бид нар дээр нөгөө төмөр замын холболт хийгдээгүй учраас автомашин учраас бид энэ дээр зохион байгуулаад явж байгаа. Тэгэхдээ бид энийг хувийн хэвшилээр хийлгүүлж байгаа шүү дээ. Онцгой дэглэм тогтоох үед “Эрдэнэс Тавантолгой” компани өөрсдөө тээврийн компани байгуулахаар тендер зарлачихсан байсныг бид зогсоосон. Машин худалдаж авахаар. Өөрөөр хэлбэл хувийн хэвшлийн ийм 20 гаруй мянган машин байхад бид өөрсдөө төр автомашин худалдаж авах нь зохимжгүй юм гэдэг ийм байдлаар явсан. Зүгээр яах вэ цаашидаа төмөр замын холболт хийгдээд эхлэхээр ачаа тээврийн асуудал ер нь жигдрэх юм байна лээ. Тэр болтол бид авто тээврээр явахаас өөр аргагүй. Тэгээд бид аль болох яах вэ, цагдаагийн болон хууль хяналтын байгууллагатай хамтраад аюулгүй байдлыг нь хангаад, тээврийн зохион байгуулалтаа хувийн хэвшилээр гүйцэтгүүлээд сонгон шалгаруулалтын байдлаар ингээд ажиллаад явж байгаа.

Уулын ажлын төсөвт өртгийг нь бид бол ер нь ингээд уулын ажлыг 12945 төгрөгөөр 1м3-ийг нь хуулдаг байсныг нь 11982 болгоод аль болохоор зардлуудыг хэмнэж байна. Тэсэлгээ дээр гэхэд 2 мянган төгрөгөөр 1м3-ийг нь тэсэлдэг байсныг 1198 болгосон гэх мэтчилэн ингээд бид боломжоор нь уулын ажлын юмнуудыг бууруулаад байгаа. Энэ гэхдээ нөгөө талдаа дизель түлшний үнэтэй шууд.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Дамдинням гишүүн хариулт хангалттай юу. Дамдинням гишүүн асууя.

Г.Дамдинням: Энэ ч одоо тухайн үеийн Засгийн газар, тухайн үеийн тэр үеийн шийдвэр гээд тэгээд “Эрдэнэс

Тавантолгой” компанийн хамгийн том борлуулалт 30 хувийн боломжийг алдчихаад, тэгээд компани өөрөө гомдол гаргахгүй яваад байна гэдэг бол их тийм зөв сонсогдохгүй л байна Ганбат захирал аа. Оффтейк гэрээ гэж нэрлээд байгаа болохоос оффтейк гэрээ биш шүү дээ. Зүгээр урьдчилгаа төлдөг энэ тэр. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Олон улсын томъёоллоор бол энэ оффтейк гэрээ биш шүү дээ. Энэ дээр танай компани ажиллах ёстой байх.

2 дугаарт тэр тээвэр дээр 20 хэдэн мянган машин ч гэдэг юм уу, 8 мянган машин. Хэд ч байж болно л доо. Танай компани хэдийг өгөхөөс л хамаарах байхгүй юу. Бүгдэд нь өгөх үүрэг хүлээхгүй шүү дээ. Тэгээд байгаль орчныхоо нөхцөл байдлыг тааруулаад л хийх ёстой байх. Уулын ажил бол буух ёстой шүү. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа шүү. Үнэ нь буух ёстой.

Т.Энхтүвшин: Үг хэлчихлээ. Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр онцгой дэглэмийн үед “Эрдэнэс Тавантолгой” компани түүнд очсон БЭТ-ийн хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл тайлан сонсож байна. Үнэхээр бид нар энэ заяагдмал баялгийг үнэ цэн хүргэж ил тод нээлттэй борлуулах ийм бодлого чиглэл бариад, тэр далд байгаад байсан юмнуудыг нь бүгдийг нь ил болгоод, биржийн хууль батлаад, ингээд ер нь олон зүйлүүдийг нэлээн тодорхой болгосон. Тэгээд үүний үр дүнгүүд нааштай үзүүлэлтүүд гарч байгаа. Угаасаа бид бүхэн мэдэж байгаа. Тэгэхээр одоо нэгэнт ингээж яваад энэ чинь бараг 1 жил боллоо шүү дээ. Тэгэхээр зэрэг би БЭТ дээр манай Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга оччихоод байгаа учраас цаашид дан ганц “Эрдэнэс Тавантолгой” биш ээ бусад төрийн өмчтэй компаниудаа саяынх шиг ийм луйвар хулгай явчихдаггүй байх тэр эрх зүйн орчныг нь л бүрдүүлэх ёстой юм. Тийм учраас таны

багаас өмчийн хууль гэдэг юм уу, төрийн болон орон нутгийн өмчит компанийн хуульд ямар өөрчлөлт оруулж байж компанийн дотоод дүрэм, журмууд ямархуу стандарт эрх зүйн зохицуулалтаар зөв гарч байж, энэ болж бүтэхгүй байгаа юмнууд цаашид гарахгүй байх тийм боломж нь байна гэж харж боловсруулж барьсан юм байна уу. Энэ бидэнд үнэхээр чухал байгаад байгаа юм. Ганц “Эрдэнэс Тавантолгой” дээр биш. 1 ийм зүйл байна гэж.

2 дугаарт бид энэ том төрийн өмчтэй компанийг үйл ажиллагааных нь зардал өртгийг бууруулах тухай л асуудал байгаа. Тийм учраас бүтцийн талын асуудал гэдэг юм уу, үндсэн үйл ажиллагааны бусдаар гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээнүүдийн ил тод, нээлттэй байдлыг хангах, өртөг зардлыг бууруулах чиглэлээр хийсэн ажлуудын мэдээллийг харсан. Энэ дээр ер нь хэдүүлээ цаашид ер нь ямархуу тийм загварчилгаагаар явах ёстой юм бэ гэдэг дээр ямар бодол санаа байна гэж. Гэхдээ энэ үндэсний том компани шүү. Тийм учраас дэлхийн энэ чиглэлийн компаниудтай өрсөлдөнө гэвэл боловсон хүчин, ажиллах хүч чадамж юмнуудаа тэд нарын түвшинд бэлтгэх тухай асуудал бидэнд байгаад байгаа юм. Тийм учраас энэ тал дээр компанийн зүгээс сая онцгой дэглэмийн үед ер нь ямархуу бодлого чиглэлүүд авч хэрэгжүүлэв гэдэг асуудал байна Энэ бол ер нь цаашид бид нарын их том бодох зүйл. Дан ганц юмыг зоосны нүхээр харж болохгүй. Өртөг зардал бууруул, төсөвт ордог юмыг нь нэмэгдүүл гээд байж болохгүй. Энэ компани өөрөө энэ зах зээл дээр өрсөлдөх чадвартай, тогтвортой, үр өгөөж өгч чаддаг тийм л аж ахуй хуулийн этгээд л байх ёстой л доо. Тийм учраас энэ талынхаа юм руу ямархуу бодлого чиглэл байна вэ гэж.

Дараагийн нэг зүйл. Хилийн нөхцөл биржийн үнээр бид нар бүтээгдэхүүнээ борлуулж байгаа. Тэгвэл ам нөхцөлөөр

борлуулж байсан үнэ тодорхой хэмжээгээр өссөн. Юу гэдэг юм 115 долларыг 180 хэдэн доллар болголоо гэж. Тэгвэл энэ зөрүү 70 орчим доллар байна уу. Энэ доллар дотор яг ам дээрээс тэр хил дээр аваачих хүртэлх үйл ажиллагааны зардал яг хэдэн хувийг нь эзлээд байгаа юм бэ. Тээврийн ч гэдэг юм уу. Дотор нь ямар ямар зүйлүүд нэмэгдээд дотор ороод байгаа вэ. Үүнийг тодорхой бид бас бодож тооцож явах ёстой гэж ингэж ойлгоод байна. Та бол биржээр худалдагдаж байгаа нүүрснийхээ үнэ рүү тэр ам нөхцөлтэй гэрээнүүдээ бүгдийг нь бараг шилжүүлчихлээ. 130.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон. Ганбат.

Ж.Ганбат: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Яах вэ, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, эрх зүйн орчинд “Эрдэнэс Тавантолгой” компани үйл ажиллагаа явуулж байгаа. Хуулийн хүрээндээ ямар нэгэн асуудал алга. Гэхдээ энд нэг л юм байна Төрийн өмчит компаниуд дээр. Бүх юм нь ил тод л байх ёстой. Ер нь хэт хаалттай нуугдмал ийм байдлаар нөгөө талдаа нууц гэдэг юмнуудад юмнуудаа оруулчихсан тэрийг нь компанийнх нь ажилчдад нь зарим нь нууцын зэрэглэлд ингээд оруулаад үйл ажиллагаанд явуулчихдаг учраас тэр ил тод биш. Тэгээд нууц гэдэг зэрэглэлд орчихсон юмыг олон нийтэд ил тод мэдээлж болдоггүй, компани өөрсдөө ч хяналтаа тавьж чаддаггүй ийм байсан. Энийг бол бид “Эрдэнэс Тавантолгой” компани дээр байсан бүх гэрээнүүдийг ил тод болгосон. Тэгэхээр ер нь цаашидаа ч энэ төрийн өмчит компаниуд нууцын зэрэглэлд юм оруулаад байх нь зохимжгүй юм гэдэг ийм байдал байна. Нөгөө талдаа энэ компанийг хэвийн үйл ажиллагааг нь явуулахад яг хараат бусаар ажиллах нөхцөлийг нь бүрдүүлж өгөх ёстой. Нөгөө талдаа цалин хангамжийн асуудлыг бас харж үзэх ёстой. Энэ хүрээндээ ч бид өнгөрсөн оны

сүүлээр ажилчдын цалинг нь 40 хувиар нэмсэн. Энэ 40 хувиар нэмэгдэж байгаагийн хүрээнд яах вэ, бусад уул уурхайн компаниудын жишигт нийцэж очиж байгаа. Тэгээд 1 ийм байдлаар үзсэн.

Боловсон хүчний хувьд бол бүтцийн хувьд яах вэ, төв оффис дээрээ жоохон данхар байсныг нь зарим нэг шаардлагагүй алба нэгжийг нь татан буулгасан. Уурхай бол хэвийн тасралтгүй үйл ажиллагаа явах ёстой. Уурхайн ажилчдыг давтан сургалтад хамруулах, бэлтгэх гэдэг ийм асуудлууд байна. Нөгөө талдаа өнөөдрөөс бид нэг зохион байгуулалтыг аваад эхэлчихсэн явж байгаа нь баяжуулах үйлдвэр 10 сая тонны баяжуулах үйлдвэр ирэх онд ашиглалтад орно. Энэ дээр ажил боловсон хүч Монгол ажилчдыг бид бэлдэх ёстой. Энэ хүрээнд ажилчдыг бид нар мэргэшүүлэх, баяжуулах үйлдвэрийг ашиглалтад орсноос хойш 1 жилийн хугацаанд гүйцэтгэгч компани нь ажиллуулж өгөөд, 1 жилийн дараа “Эрдэнэс Тавантолгой” компанид бүрэн хүлээлгэж өгөх ёстой юм байна лээ. Энэ боловсон хүчнийг бид нар бэлдэх зайлшгүй шаардлага үүсэж байгаа. Яг өнөөдөр ний нуугүй хэлэхэд баяжуулах үйлдвэр дээр хяналт тавих, энийг ажиллах манай боловсон хүчин дутагдал, хомсдол байна. Бид одоо хийгдэж байгаа ажил зөв явж байгаа эсэхэд бас дүгнэлт хийх ийм ийм байдлаар л хүмүүсээ бэлдэх шаардлагатай юм байна гээд газар дээр нь зарим үйлдвэрүүдийг бас хүмүүс явж үзүүлэх гэх мэтчилэн ажлыг зохион байгуулж ингэж ажилласан. Ер нь цаашид яг мэргэшсэн тийм яг нарийн баяжуулах үйлдвэрийн чиглэлийн мэргэжилтнүүдийг бэлдэх, илүү нарийн мэргэжил эзэмшүүлэх ийм шаардлагууд үүсэж байгаа. Тэгээд энэ дагуу бид зохион байгуулалттай арга хэмжээг ТИС-ийн Уул уурхайн сургууль энэ тэртэй хамтраад авч хэрэгжүүлээд ингээд явж байгаа.

Биржээр тогтоосон үнэ бол яах вэ, дунджаар ингээд яах вэ зах зээлийн нөхцөл байдлаасаа хамаараад янз бүр байгаа юм. Одоо энэ дээр 1 жишээ. Жишээ нь одоо биржээр тогтоосон үнэ бол бид нар 152,9 ам.доллар байгаа, тэгэхэд уурхайн ам бол 83 доллар гээд, зөрүү бол бид нар жишээ нь 69,9 ам долларын нэмэлт орлого олоод явж байгаа. Үүн дээр хил нөхцөлөөр бид нар биржээр 152,9 сая ам.доллароос тээврийн зардал нь 15,6 ам.доллар, терминал дээрх ачиж буулгах зардал гэдэг нь ачих зардал нь 1,5 доллар гээд, яг бид нар ингэж хил нөхцөлөөр зарснаар 52,7 долларын нэмэлт яг цэвэр орлого, ашиг “Эрдэнэс Тавантолгой” 278.6 сая ам.долларын нэмэлт орлого “Эрдэнэс Тавантолгой” компани олоод ингэж ажиглаж байгаа.

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тэгэхээр зэрэг үнэхээр үйл ажиллагаа дээр бас сайн сайн зүйлүүд байгаад байгаа юм. Тэгэхээр би юу гэх гээд байна гэхээр зэрэг төрийн өмчтэй байна уу, хувийн өмчтэй байна уу, хуулийн этгээдийн өөрийнх нь дархлаа эрх зүйн зохицуулалт хамгаалалтыг их тодорхой болгомоор болчихоод байгаа юм. Янз бүрийн нөхцөл байдлаар өөрт хамааралгүй ачаа үүрүүлдэг юмыг л больчих ёстой юм ерөөсөө бид. Тийм учраас танай үндсэн үйл ажиллагаатай гэдэг юм уу бараг хамааралгүй шахуу том том төслүүд санхүүжүүлээд байгаа явдал энэ нэгжсийн өөрийнх нь өгөөжийг бууруулаад болж өгөхгүй байгаа байхгүй юу. Яг үнэндээ. Тэгэхээр зэрэг энэ талаас нь би тэр эрх зүйн зохицуулалтын талын юмыг ярьсан юм. Дээр нь энэ бол бид нар хэн нэгэнтэй хөрөнгө оруулалт нийлж байгуулсан аж ахуй биш ээ. Тийм учраас заавал гаднын үнэ цэнтэй аудитын байгууллага ажиллуулах ер нь хэрэг.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүнд 1 минут нэмж өгөөрэй. Гүйцээгээд асууцх.

Ж.Батжаргал: Монголын өөрийнх нь үндэсний бүхэл бүтэн аудитын систем тогтолцоо чадамж нь байж байна. Энэ дээрээ тулгуурлаад үзэж харах ёстой юмаа үзэж хараад хэдэн тоогоо баталгаатай болгочихвол бид хэдэд бололцоо байгаа шүү дээ. Тэгээд тэр уул уурхайн салбарын нарийн улсуудаа татаж авчраад шинжээчээр ажиллуулаад ингээд чиглэлээ тодорхойлчих бололцоо байгаа шүү дээ. Заавал гадагш нь юм шилжүүлж байх шаардлага байгаа юм уу. Ер нь энийг Их Хурал, Засгийн газар цаашид бодмоор байгаа юм. Тэгээд л жигтэйхэн баталгаатай юм хийнэ гэхээрээ л том том, өндөр өртөгтэй хяналт үнэлгээний аудитын байгууллага авчраад ажиллуулсныгаа их сайн гэж ойлгоод байгаа явдал бол бас ч тийм зохимжтой зүйл биш. Яг нарийндаа. Дээр нь баахан хөрөнгө гаргаад хийчихсэн энэ замуудыг хэдүүлээ Их Хурал нь ч тэр, Засгийн газар нь ч тэр, аж ахуй нь ч тэр онцгой анхаарал хандуулж аль болохоор цаг хугацаа нааш нь татаж холболт.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Асуулт уу. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон Ганбат дарга.

Ж.Ганбат: Яах вэ, Олон улсын аудит оруул гээд Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэртэй. Яах вэ, хөндлөнгийн хараат бусаар аудит оруулаад, үүний үр дүнд компанийн санхүүгийн байдал, нөхцөл байдлыг нь нэг тодорхойлох нь зөв зүйтэй гэдэг байдлаар оруулчихсан байгаа юм. Давхар Үндэсний аудитын газраас аудит нэлээн өргөн хүрээг хамарсан бүрэлдэхүүнтэй бол Үндэсний аудитын өөрийнх нь аудит эхэлчихсэн ингээд явж байгаа. Өмнө нь бол Үндэсний аудитын газартай гэрээтэй манай дотоодын хувийн аудитын компаниуд өмнөх 3 жилд аудит

хийгээд, дүгнэлтээ гаргаад явж байсан юм байна лээ. Тэгээд яах вэ, энэ бүгд дээр нь тэр олон улсын аудит, Үндэсний аудит өөрсдөө өргөн хүрээтэй аудитаа хийгээд, тэгээд бас зөвлөмж, дүгнэлтээ гаргаад ингээд цаашаа явчих байх гэдэг ийм байдлаар. Ер нь бол хараат бус байдлаар нэг дүгнэлт гаргуулаад, дүгнэлтээ цаашаа зөвлөмжөө аваад явчих нь зүйтэй гэдэг ийм байр суурь дээр аудитаар хандсан.

Т.Энхтүвшин: Төмөр замын холболтууд. Нэмэлтээр ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Ер нь “Эрдэнэс Тавантолгой” компани дээр яг өөрийнх нь үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх ийм байдлаар явж ирсэн нь үнэхээр энэ компанийг санхүүгийн хувьд маш хүндрэлтэй байдлаар оруулчихсан. Тэр өр төлбөрийн хувьд бол 4,3 их наяд байсныг одоо 2 их наяд болгоод бууруулаад бууруулаад байна. Яг төмөр замууд үнэхээр бид тээвэрлэлтийг амжилттай экспортыг нэмэгдүүлэхийн тулд төмөр замын төсөл бол зайлшгүй энэ компанитай хамааралтай. Төмөр замын холболтын төслүүд явна. Нөгөө талдаа ингээд манай “Эрдэнэс Тавантолгой” компанид хамааралгүй юмнуудыг одоо жишээ нь бид “Тавантолгой түши” гэдэг компанийг цаашдаа “Эрдэнэс Тавантолгой” компани байнгын аваад яваад байх ёстой юу. Үүнийг яах вэ гэдэг асуудлыг бид бас ярьж байгаа. Нөгөө талдаа Багануур Шивээ-Овоогийн асуудлыг бид жил болгон ингээд санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлээд явах нь зөв үү, буруу юу гэдэг бас ийм асуудлуудыг ингээд яг өөрсдийн үндсэн үйл.../минут дуусае/

Т.Энхтүвшин: Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа “Эрдэнэс Тавантолгой” компанийн үйл ажиллагаатай, бас хийсэн ажлуудтай нь танилцаад сууж байгаа юм. Онцгой

дэглэм тогтоосноос хойш үндсэндээ тодорхой хэмжээнд мэдэгдэхүйц ажлууд сайжирсан гэж үзэж байгаа. Биржийн арилжаа мөн зэрэгцэж явж эхэлсэн. Биржийн арилжаа дээрээс үндсэндээ тодорхой хэмжээний ашгуудыг олж байгаа. Тээврийг сонгон шалгаруулалтаар хийгээд эхэлсэн. Маш олон тээврийн компаниуд оролцож байгаа. Энэ дээр бас либералчлал бий болоод тодорхой хэмжээний тээврийн асуудлуудаа шийдээд явж байгаа гэж ойлгож байгаа.Оффтейк гэрээ байхгүй. Өр төлбөрөө тодорхой хэмжээнд багасгасан байдалтай байгаа юм байна. Манай “Эрдэнэс Тавантолгой” компанийнхан сайн ажиллаж байгаа. Бас онцгой дэглэм тогтоохоос өмнө үнэхээр замбараа байхгүй л нөхцөл байдал үүсчихсэн байсан шүү дээ. Тийм учраас энэ дээр сайн ажиллаж байгаа гэж үзэж байгаа. Өр төлбөрөө тодорхой хэмжээнд багасгаад явж байгаа. Төрийн өмчит болон бас 1072 хувьцаа эзэмшдэг ард иргэд бий. Ноогдол ашгаа өгөх бололцоо ер нь хэдийнээс үүсэх вэ. Ард иргэдийн хүсэн хүлээж байгаа зүйл бол ингээд “Эрдэнэс Тавантолгой” компани тодорхой хэмжээнд ашиг алдагдал нь баланс нь баригдаад өмнөх шиг замбараагүй байдал байхгүй болчихсон юм байна. Бид нарт хэзээ ноогдол ашгаа өгч эхлэх бол гээд харж байгаа л даа. Ард иргэд яг гар дээрээ хэдийнээс ноогдол ашгаа авах бололцоо үүсэх вэ. Нэг л асуулт байна. Энэ дээр л хариулаад өгчих.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Аубакир гишүүний асуултад хариулъя. “Эрдэнэс Тавантолгой” компанийн 18,4 хувийг 2012 оны 4 сараас өмнө төрсөн Монгол Улсын 2,5 сая иргэд эзэмшдэг юм байна лээ. Эзэмшдэг. Энэтэй холбогдуулан ноогдол ашгийн асуудлууд бол өмнөх жилүүдэд 2019 онд ашигтай ажилласан ноогдол ашгийг 2020 онд ноогдол ашиг хуваарилсан байгаа. Энд бол 18,4 хувийн

иргэдэд хувь эзэмшиж байгаа иргэдэд бол ноогдол ашгийг тухайн үед олгоод 1 иргэнд 96 мянган төгрөгийн ноогдол ашгийг 1 удаа тараасан юм байна лээ. Тэрнээс хойш ноогдол ашиг өгөөгүй. Одоо бид өнгөрсөн 2022 оны хувьд ноогдол ашгийн асуудал яригдаад иргэд бол энэ асуудал дээр нэлээн юм яригдаад байгаа. Тэгэхээр бидний хувьд яг өнөөдрийн байдлаар Засгийн газрын түвшинд хувьцаа эзэмшигчдийн түвшинд бол ноогдол ашгийн асуудлыг танилцуулсан. Бид 2019 онд ингэж тарааж байж, одоо бид энэ асуудлыг яах вэ гэдэг ийм байдлаар хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн түвшинд асуудал ярьсан. Өр төлбөрийн асуудал байна 1-д.

2-т Засгийн газраас онцгой дэглэм тогтоочихсон, үйл ажиллагааг нь жигдрүүлэх санхүүгийн хувьд бас боломжтой түвшинд хүргэх энэ шаардлагуудыг хангасны дараа ноогдол ашиг тараах асуудлыг авч үзэх нь зүйтэй юм гэдэг байдлаар ингээд шийдвэрлэчихсэн. Тэгэхээр онцгой дэглэмийн хугацаа бол энэ оны 10 сарын 26-нд дуусгавар болж байгаа. Үүний дараа мэдээж энэ шийдлийг ноогдол ашиг тараах эсэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гаргах байх. Мэдээж санхүүгийн байдал саяын хэлдэг өр төлбөр, одоо бид өр төлбөрийг барагдуулаад цаана нь дахиад 2 их наядын өр төлбөр байна. Энэ бас өр төлбөрүүдийг бид бас зайлшгүй барагдуулах ийм шаардлагууд байгаа. Тэгээд дахиад бид нэмж Төмөр замын төслүүд, баяжуулах үйлдвэрийг дуусгах ийм шаардлагуудтай байгаа. Бид ноогдол ашиг уг нь тарааснаас илүү ядаж угаах үйлдвэр, баяжуулах үйлдвэрээ ашиглалтад оруулаад төмөр замаа холбочих юм бол “Эрдэнэс Тавантолгой” компанийн бид нарын нэмэлт орлого олоод байгаа 70 гаруй долларын нэмэлт орлого олоод байгаа 1 тонн нүүрснээс гэдэг энэ орлого бид нар нэмж орно. Өнөөдөр бид нар 20 гаруй сая, 23 орчим сая тонн нүүрс экспортлоод байгаа бол

энэ бол төмөр замын холболтыг хийчих юм бол 2 дахин нэмэгдэх бололцоотой. Энэ асуудлыг шийдсэний дараа уг нь ноогдол ашгийн асуудлыг авч үзэх нь зүйтэй юм гэдэг ийм байр суурийг компани баримталж байгаа.

Т.Энхтүвшин: Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Баярлалаа. Яах вэ онцгой дэглэм үр дүнгээ өгсний хувьд бол өгсөн л гэж харагдаж байна л даа. Гэхдээ 2, 3 яг тодорхой сэдэв дээр би тогтоож ярья гэж бодож байна.

1 дүгээрт оффтейк гэрээний асуудал ер нь тэгээд л нууцаас ил гаргалаа гээд л пижигнээд л, тэгээд л чимээгүй болчихлоо л доо. Яг үнэн хэрэгтээ оффтейк гэрээ чинь жилийн дундаж дискаунт нь зах зээлийн үнээс 32 хувь байна шүү дээ. Өөрөөр хэлбэл энэ чинь доллароор жилийн 32 хувийн хүүтэй санхүүжилт авсан л гэсэнтэй адилхан байхгүй юу. Тэгээд энэ хэмжээний ийм өндөр өртөгтэй санхүүжилт аваад, за яах вэ тийм өндөр өртөгтэй санхүүжилт олдсон юм байлгүй. Гэхдээ энийгээ үр өгөөжтэй юманд санхүүжүүлээд тэр нь 32 хувиас өндөр өгөөжтэй байсан бол бас нэг өөр хэрэг. Гэтэл тэгээд байхгүй мухар далий төмөр замтай. Тэгэхээр энэ асуудлыг “Эрдэнэс Тавантолгой” удирдлагын түвшинд ярьдаггүй юм аа гэхэд энэ бол Их хурал, Байнгын хороо, төр засгийн хэмжээнд ярих л ёстой асуудал шүү дээ. Тэгэхлээр энэ дээр та нар гэрээгээ оффтейк гэрээнүүдээ биелүүлээд яваад байна гэж би ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр яг цуцалж болдоггүй юм уу энэ гэрээнүүдээ. Одоо энэ төлбөр жилдээ 32 хувийн үндсэндээ хүү төлдөг гэрээнүүдээ зогсоож болдоггүй юм уу. Энэ хэмжээний л танайд илүү орлого, ашиг олж ирнэ шүү дээ. 1 дүгээр асуудал.

2 дугаарт баяжуулах үйлдвэр чинь миний ойлгож байгаагаар энэ оны эцсээр уг нь ашиглалтад орно гэж ойлгодог

байсан нь үгүй болж таарч байна. 2024 онд ашиглалтад орох юм байна шүү дээ. Тэгээд танай 17 дугаар хуудас дээр төслүүдийн явц ингэсэн слайд байгаа. Үүний явцыг нь харахад болохоор их л бага харагдаад байх юм. 2024 оны хэзээ гэлээ дээ, 2024 ондоо ашиглалтад орох бараг орж чадах юм уу, үгүй юм уу гэж л харагдаад байна. Нэг бол та нар явцаа хэт доогуур үнэлээд байна. Өөрөөр хэлбэл нөгөө туслан гүйцэтгэгч компаниуд чинь ажлаа хийхийн хувьд хийчихсэн, та нар ажлыг нь хүлээж авахгүй тодорхой хэмжээгээр нь төлбөрийг нь төлөхгүйгээр ингэж харагдуулаад байна уу. Яагаад гэвэл ийм бас нэг шүүмжлэл байдаг байсан шүү дээ “Эрдэнэс Тавантолгой” дээр. Компаниуд нь ажлаа хийдэг, өөрсдийнхөө хөрөнгөөр. Төлбөр тооцоог нь хийж өгдөггүй. Тэгж бас нэг санхүүгийн ашигтай, ашиггүй юуг нь гаргаж өгдөг гэж яриад байдаг. Ийм юм байгаа юу, байхгүй юу.

3 дугаарт ер нь тэгээд яах вэ онцгой дэглэм бол түр хугацааны л зохицуулалт гэж ойлгох ёстой биз дээ. Үнэхээр шаардлагатай болоод л онцгой дэглэм тогтоогоод санхүү, удирдлага, бусад гэрээний менежментийн асуудлыг гартаа аваад, цэгцлээд ил тод болгоод, үйл ажиллагааг нь сайжруулаад ашигтай болгосон. Одоо гэхдээ цаашидаа урт хугацаанд байнга л онцгой дэглэмтэй ажиллана гэсэн ойлголт байхгүй байлгүй дээ. Өөрөөр хэлбэл Ганбат захирал таны бодол юу байдаг юм. Тодорхой хэмжээгээр сунгаад, тэгээд хэвийн горимдоо орно гэж төлөвлөж байна уу. Аль эсвэл ямар цаг хугацааны баримжаа байна. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Оффтейк гэрээтэй холбоотойгоор төмөр замын төслүүд байгаа. Энэ төслүүд бол тухайн үед Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэртэй энэ гэрээнүүд байгуулагдчихсан юм байна

лээ. Тийм учраас би Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурал, Засгийн газрын өмнөөс би энэ гэрээг ингэх ёстой, тэгэх ёстой гэдэг ийм дүгнэлт гаргана гэвэл, би энэ онцгой дэглэм тогтоосны дараа очоод бол энэ оффтейк гэрээнүүдийг өөрчилье гэдэг асуудлыг удаа дараа тавьсан. Та нар үүнийгээ ам нөхцөлтэй гэрээг чинь хил нөхцөл рүү шилжүүлбэ, энэ дээр хэлэлцээрт орё гэдгийг удаа дараа “Бодь групп”-д асуудлуудыг нь тавьсан. Энэ дээр бол нөхдүүд нэгэнт байгуулагдчихсан гэрээ. Бид бол үйл ажиллагаа ажлаа хийгээд ер нь дуусах шатдаа орчихсон ийм юм явж байхад энэ асуудлыг хэрвээ ингэж босгож тавих байсан юм бол бид гэрээг хийх байсан уу, үгүй юү гэдэг асуудал яригддаг юм байна лээ. Нөгөө талдаа энэ бол санхүүжилтийн асуудал гээд хэд хэдэн удаа энэ асуудал ярьж байсан. Ийм учраас бид ямар зарчим баримталсан бэ гэхээр гэрээнүүдийг бид нар хугацааг нь ингээд дуусгавар болсон гэрээнүүд цуцлаад цуцлаад явсан. Дахиж сунгахгүйгээр. Тэгээд саяын хэлдэг ер нь оффтейктэй холбоотой гэрээнүүдийн асуудлууд бол буураад нийтдээ 3 төсөлтэй холбоотой 3 гэрээний л асуудал байна. Зарим нэг компаниуд тэр нүүрс баяжуулах үйлдвэрийн барьж байгаа оффтейк гэрээтэй компанитай бид хэлэлцээрт орсон. Нийтдээ 90 хувийг нь нүүрсээр, 10 хувийг нь мөнгөөр төлөх байсныг бид нар хэлэлцээрт орж байгаад 70 хувийг нь нүүрсээр, 30 хувийг нь мөнгөөр өгье гэдэг дээр тохиролцож ядаж бид нар 20 хувийн нэмэлт өөрийн талд ашигтай ийм байдлаар юмнуудыг нь шийдүүлэх байдлаар юмнуудыг нь ингэж хэлэлцээрт ороод явсан байгаа. Тэгэхээр яах вэ бид ажиллаагүй биш ажилласан. Тэгээд яах вэ тодорхой түвшинд тухайн үед бол асуудал хийсэн. Мөн энэ дээр бас Үндэсний Аудитын газраас бас энэ дээр нөхөн төлбөрийг бас нэхэмжлэх ёстой гэдэг ийм байр суурийг бас бид нарт хэлж байсан. Бид бол аль болох хэлэлцээрт ороод эд нар дээр гэрээний нөхцөлүүдийг нь өөрчлөх гэж удаа дараа үзсэн. Тэгээд ойлголцоогүй

учраас, яах вэ 1 компанитай нь бол ойлголцоод сая хэлдэг 90 хувийг нь нүүрсээр, 10 хувийг нь мөнгөөр гэдгийг бид нар 70 хувийг нь нүүрсээр гэдэг байдлаар ойлголцож чадаад ер нь баяжуулах үйлдвэр барьж байгаа компанитай тохиролцоод ингээд явж байгаа юм.

Угаах үйлдвэр “Эрдэнэс Тавантолгой” компани дээр 2 төрлийн угаах үйлдвэр төслөө хийж байгаа. Нэг нь бол одоо бид яг өөрсдөө санхүүжүүлээд, нойтон аргаар угаах үйлдвэр угаасаа гэрээгээрээ 2024 оны 7 сард ашиглалтад орох байсан юм байна лээ. Энийг бол бид хэлэлцээр хийж байгаад наашлуулаад 24 оны 5 сард ашиглалтад оруулахаар ингээд тохиролцсон. Ажлын гүйцэтгэл нь 57,3 хувьтай явж байгаа. Энийг гүйцэтгэгч компани хугацаандаа өгнө гэдэг ийм байдлаар. Хугацаандаа оруулсны дараа 1 жил бол эд нар өөрсдөө ажиллуулж хүлээлгэж өгөх юм байна лээ. Уг нь энэ баяжуулах үйлдвэр нь 10 сая тонны хүчин чадалтай, ус нь бэлэн болчихсон. Энэ төсөл бол ингээд хугацаанаасаа 2 сарын өмнө ашиглалтад оруулахаар байгаа. Нөгөөдөх нь тэр хуурай аргаар баяжуулах гээд тэр бол нөгөө төрхувийн хэвшлийн түншлэлээр ингээд “Эрдэнэс Тавантолгой” компаниас мөнгө гараагүй. Яг хувийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа төсөл байгаа. Энэ бол уг нь энэ онд орох ёстой байсан. Одоогийн байдлаар энэ чинь 2 сарын хоцрогдолтой явж байгаа. Бид бол та нар төслөө дуусга гэдэг шаардлагыг тавьж байгаа. Үйлдвэрийнх нь төслүүд нь бол тэр Бортээгийн уурхай дээр гээд ашиглах ийм хуурай аргаар баяжуулах нүүрс бол энэ онд орохоор ингээд явж байгаа.

Дараагийн асуудал бол Засгийн газраас нэгэнт шийдвэр гараад онцгой дэглэм тогтоосны гол зорилго бид нар Монгол Улсад орох валютаар орох урсгалыг нэмэгдүүлэх, экспортоо нэмэгдүүлэх, хэвийн үйл ажиллагааг жигдрүүлэх, санхүүгийн хувьд бас хэвийн

нөхцөлд оруулах ийм үүрэг аваад энийг нь цэгцлээд явж байна. Ер нь бол байнгын онцгой дэглэмтэй ажиллах нь буруу. Мэдээж засаглалын хувьд компанийнхаа зарчмаар гүйцэтгэх захирал нь удирдаад ингээд явах ёстой. Гэхдээ.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ганбат даргын микрофоныг нэмээд өгөөрэй. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон. 1 минутаар нэмээд өгөөрэй.

Ж.Ганбат: Засаглалын хувьд уг нь хандлагаа өөрчлөөд үйл ажиллагаагаа ил тод нээлттэй болгоод ингээд цаашаагаа явахад болохгүй юм байхгүй. Мэдээж гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багууд багийн хувьд бол хараат бусаар ажиллах бол улс төрийн нөлөөллөөс ангид яг ингээд хариуцлагаа ч үүрдэг ийм байдлаар ажиллах зайлиггүй шаардлага байгаа юм байна лээ. Ямар нэгэн байдлаар 1 номерт бол улс төрийн нөлөөллөөс ангид ажиллах л ёстой юм байна лээ. Гүйцэтгэх удирдлага бүрэн хариуцлагаа хүлээгээд ингээд энэ бүх нөхцөлийг нь бүрдүүлээд өгөхөд цаашдаа энэ компани ил тод нээлттэй ингээд яваад үйл ажиллагаа нь тогтворжуулаад явахад болохгүй юм байхгүй. Нөгөө талдаа худалдан авагч болон хөрөнгө оруулагч бусад аж ахуйн нэгжүүдтэйгээ яг ил тод нээлттэй ийм байдлаар харьцах шаардлагатай. Өмнө нь бол янз бүрийн байдлаар гэрээний үүрэг болон хэлсэн ярьснаасаа буцдаг, үүнээс болоод бас 2 орны асуудлын хэмжээнд хүртэл юм яригдаж байсан юмнууд бол байдаг л юм байна лээ. Тэгэхээр онцгой дэглэмийг бас тодорхой хугацаанд үр.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Амартүвшин гишүүн лавлах юм байна. Амартүвшин гишүүний микрофоныг өгөөрэй.

Г.Амартүвшин: Ганбаа захирал аа, энэ нөгөө нууцаас гарсан оффтейк гэрээнүүдийн нийт дүн нь хэд байлаа. Та

нэг сануулаад өгөөч. Ялангуяа нөгөө төмөр замтай холбоотой.

2 дугаарт ер нь ингээд тэр нууцаас гарсан оффтейк гэрээнүүдийг цуцлах үндэслэл хангалттай байгаа юм биш үү. Энэ чинь тийм өндөр өртөгтэй 32 хувийн жилийн хүүтэй санхүүжилт авчхаад нөгөө төмөр замаа та нар ашиглаж чадахгүй байгаа биз дээ. Энэ чинь холболт байхгүй мухар юм чинь. Тэгэхээр энэ чинь нөгөө яг гэрээний дагуу та нарт амласан бүтээгдэхүүн үйлчилгээг чинь нийлүүлж өгөөгүй л байгаа байхгүй юу. Тэгэхээр тэрийг үндэслээд гэрээгээ цуцлаад, зогсоогоод, тэгээд гэрээнийхээ заалтын дагуу ингээд Арбитр, шүүхээр явах боломж байгаа юм биш үү. Энэ чинь арай л өндөр өртөгтэй боломжоо алдаад байгаа юм шиг л харагдаад байна л даа.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Төмөр замын төслүүд дээр нийт өртөг нь 3 тэрбум ам.долларын өртөгтэй. Ингээд Тавантолгой-Гашуунсухайт төмөр зам, Тавантолгой-Зүүнбаян төмөр зам, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян төмөр замуудыг холбогдох төмөр зам, Тавантолгой нүүрс ачих логиستيкийн төв байна. Тэгээд Богд хаан төмөр зам нийлээд 3 тэрбум ам.долларын өртөгтэйгөөс үүнээс 1,5 тэрбум ам.долларыг нь олгочихсон. Тэгээд төмөр замын яг цэвэр оффтейк гэрээнүүдтэй холбоотой ингээд явчихсан байгаа. Нөгөөдөх нь бол бүтээгдэхүүн үйлдвэр бий болгох нь нүүрс баяжуулах үйлдвэр, Загийн ус, гүний ус ашиглах газрын тос дамжуулах хоолой, Тавантолгой дулааны станц нь арай эхлээгүй энэ дээр 1 тэрбум долларын өртөгтэй. Олгосон дүн нь 236,3 сая ам.доллар орчихсон ийм төслүүд бол оффтейк гэрээтэй ингээд явчихсан байгаа.

Тэгээд би бас сая энэ гэрээнүүдтэй холбоотой байхад бид нүүрсээр төлбөрийг нь барагдуулахгүй, үнийг нь өөрчлөх гэж хэлцэлд орох гэж бас удаа дараа үзсэн л дээ. Яах вэ ажлууд нь.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг 1 минутаар сунгаад өгөөрэй.

Ж.Ганбат: Тавантолгой-Гашуунсухайт төмөр зам дээр бол ажил нь 87,4 хувьтай, Тавантолгой-Зүүнбаян төмөр замын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй, Тавантолгой-Гашуунсухайт-Тавантолгой Зүүнбаян төмөр замын ажил 93.7 хувийн гүйцэтгэлтэй, Тавантолгой нүүрс ачих логиستيкийн төвийн ажил 14,6 хувийн гүйцэтгэлтэй. Бид яах вэ, нөгөө холболтгүй ч гэсэн энэ төмөр замаар бид нүүрсээ зөөгөөд яг тэр Гашуунсухайт чингэлэг терминал хүртэл нь зөөгөөд, тэндээс цаашаа бас бид нар авто тээвэрт тээвэрлэх байдлаар бас ачааллаа хөнгөлөхийн тулд ийм зохион байгуулалтын арга хэмжээг Тавантолгой төмөр замтай хамтраад хэрэгжүүлээд явж байгаа. Яах вэ, зүтгүүрийн хувьд хүндрэлтэй асуудлууд бол байгаа. Зүтгүүрээр ишийдчих юм бол бид арай тарифын хувьд хямд байдлаар холболтгүй ч гэсэн холбох хүртэлх хугацаанд энийг ашиглаад явах бүрэн бололцоотой юм байна лээ.

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн асууя.

С.Ганбаатар: Би ч Оюутолгой гэж 18 жил ярьсан. Одоо бараг нүүрс судлаач болох нь дээ. Би хэдэн асуулт асууя. Аудитын материал та нарын сайт болон саяын өгсөн танилцуулгуудаас би мэдээлэл асууя. 588,8 сая долларыг Засгийн газрын 362 дугаар тогтоолын хүрээнд төвлөрүүлсэн гэсэн байна. Шилэн дансны мэдээллээр 315 сая доллар л байгаа. Орлого орсон байгаа. Шилэн данс худлаа ярьсан уу,

БЭТ Ганбат худлаа ярьсан уу эсвэл данс андуураад өөр тийшээ шилжүүлсэн үү. Надад тодруулж хэлж өгнө үү. Хэрвээ шилэн данс үнэн бол 315 сая доллар үнэн бол та Засгийн газрын 362 дугаар тогтоол болон өнгөрсөн яг жил орчмын өмнө ярьж байсан 500 сая долларыг 12 сарын 31-ний дотор оруулна гэсэн, төсөвт бүрдүүлнэ гэсэн, орлого оруулна гэсэн энэ зорилт биелээгүй байна гэж би үзэж байна.

2 дугаарт би Хөгжлийн банканд өртэй “Моннис” гэдэг компанийн гэрээт тендерийн тухай маш их ярьсан. Өнгөрсөн удаад. Тэгээд зүгээр та нар дараагийн ч байна уу, хэн нь шалгарах нь надад хамаагүй. Намд хандив өгдөг ийм том гарууд зүгээр хуульгүй тендер авдаг байдлыг зогсоо л гэж байгаа. Надад тэр компаниудыг нь мэдэх ч үгүй. Энэ асуудал яагаад шалгарсан юм бэ. Одоо энийг бол би дараагийн холбогдох байгууллагад нь өгөхөөс аргагүй байдалд орж байна.

3 дугаарт түрүүн Дамдинням гишүүн маш чухал юм асуусан. Уурхайн ашиглалтын өөрийн гэсэн техник худалдаж авах тендерийг яагаад зогсоосон юм бол. Өөрийн техникээрээ та нар 6 мянган төгрөгөөр л хийх ажлыг гэрээт компаниар 12 мянган төгрөгөөр хийлгэж байна. Үнэн шүү дээ. Энэ хөрс хуулалт бол аймаар өндөр. Энэ бол ашиг сонирхлын зөрчил байна гэж би үзэж байна. Уурхайн үйлчилгээний автомашиныуд чинь бүгд зогсчихсон байгаа. Машин техникийн түрээс хэдэн тэрбумыг зарцуулж байгаа вэ. Тодорхой хариулж өгнө үү. 3 дугаар асуултаа асуучихлаа.

4. “Эрдэнэс Тавантолгой”-н лицензийн талбайгаас Энержи ресурс компани 6,6 сая м2 талбайг 2023 оны 4 сард шилжүүлсэн гэсэн мэдээллийг би аваад байна. Энэ ямар учиртай вэ. Тодорхой хариулж өгнө үү.

5. Хил нөхцөлөөр нүүрс тээвэрлэх ерөнхий шалгаруулалтад тэнцсэн 100 гаруй Монгол компанийн хэдэн мянган жолооч надад тоо баримтаараа байна. Хэдэн мянган жолооч өдий хүртэл ажилгүй, орлогогүй байна. Энэ дээр ямар арга хэмжээ авсан бэ. Фэйсбүүкээр, лайваар бөөн юм болж байсан. Ганбат чи хариуцах ёстой энийг. Нүүрс тээврийн “С” зөвшөөрлийг зөвхөн Хятад эзэнтэй олон машинтай компани л авах нөхцөл бүрдчихлээ. Энэ яагаад зохицуулж чадсангүй вэ. Би хүсвэл тоо баримт нэр устай ярьж болно шүү.

Дараагийн асуулт. Онцгой дэглэм тогтоосноос хойш яагаад үндэслэлгүйгээр 75 хүнийг /надад байгаа мэдээллээр. Би үйлдвэрчнийхэнтэй байнга харьцаж байгаа/ 75 хүнийг ажлаас хуульгүй халчлав. Яагаад хөдөлмөрийн хууль баримталсангүй вэ. Та нар БЭТ болно гэдэг чинь хуульгүй доор хулгай, мэдлэггүй доор боол гэдэг үгийг хэрэгжүүлнэ гэсэн үг биш шүү. Онцгой дэглэм нэрээр 57 хүнийг ямар ч сонгон шалгаруулалтгүйгээр ажилд томилсон байна. Авлига бууруулна гэж очсон байж яагаад Авлигын эсрэг хууль, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийг баримтлахгүй байна вэ. Сангийн яам, Төрийн банк, Хөгжлийн банк, Татварын маргаан таслах зөвлөлд ажиллаж байсан нөхдөөр дүүрсэн байгаа. Хүсвэл би нэр устай, анкетыг нь хэлж болно. Хүний нэр учраас зүгээр би асуултаар асууя. Яагаад.

Есөд нь уурхайн хөрс хуулалтын коэффициент яагаад нэмэгдсэн бэ.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Нийтдээ 2022 онд 588 сая ам.доллар оруулж байна. Энэ яах вэ 588,8 сая долларын үнэлгээтэй 6,6 сая тонн нүүрс борлуулсан. Гэхдээ нөгөө мөнгө нь урьдчилаад авчихсан байсан

155,5 сая доллар. Энэ бол мөнгө нь Монгол улсад орж ирээгүй. Бид яг бэлнээр 416,6 сая ам.доллар орж ирсэн. Энэ дээр нэг ийм тэр аудитын таны хэлээд байгаа тэр компанийн асуудал бол ямар юм яригдаж байгаа вэ гэхээр бид үүнийг 362 дугаар тогтоол бол 2022 оны 10 сарын 5-нд гарсан тогтоол 5-аас тооцож байгаа юм. Бид Засгийн газрын 362 дугаар тогтоол 10 сарын 5-нд гарсан. Энэ тогтоолоосоо тооцохоор 416,6 сая ам.доллар Монгол банканд төлсөн байгаа. Онцгой дэглэм тогтоосон, намайг томилогдсоноос хойших хугацаагаар яривал тэр 316 гэдэг тийм тоо гарч байгаа. Бид бол тэр аудитын компанид бол саяын хэлдэг зөрүү нь ийм юм байна. Бид өмнөх тэр урьдчилж авсан орлогын хүрээнд 155 сая ам.долларыг орох байсныг бид өмнө нь аваад идчихжээ. Энэ нь бол Монгол Улсад орж ирээгүй, хилийн гадна үлдсэн. Өмнөх доллар нь бид нар 362-ын биелэлтээсээ хойшихыг нь тооцож үзэхээр ийм байна гэдэг тайлбарыг нь өгөөд ингээд уг нь ойлголцоод явсан. Одоо яг энэ дээр бол бодитоор ийм л байна.

2 дахь нь бол “Моннис” гэж компанитай бид нар энэ оны 2 сар, 3 сард бид нар хөрс хуулалтын 2 багц тендер шалгаруулсан. Энэ дээр “Моннис” гэж компанитай байгуулсан “Моннис” гэж компани дээр гэрээ нь бол цуцлагдсан. Тэр сонгон шалгаруулалтыг нь цуцалсан. “Моннис” гэж компани тэр тендерт оролцсон компаниудын маргаан шүүх дээр явж байгаа. Бид одоогоор “Моннис” гэж компанитай хөрс олборлолт дээр гэрээ байхгүй. Өмнөх гэрээ нь намайг очихоос өмнө байсан гэрээ нь 3 сард хугацаа нь дуусгавар болоод, тэр гэрээ нь дуусгавар болгочихсон. Тэрний дараа сонгон шалгаруулалт дээр шүүхийн маргаан үүссэн учраас шүүх дээр энэ асуудал явж байгаа. Одоогоор бол “Моннис” гэж компани дээр бид ямар нэгэн байдлаар олборлолт дээр гэрээгүй явж байгаа.

Дараагийнх нь тэр өөрийн техникээрээ гээд “Эрдэнэс Тавантолгой” компани онцгой дэглэм тогтоохоос өмнө бол 1,2 их наядын үнэлгээтэй тендерийг зарласан байсан. Үүнээс 900 гаруй тэрбум бараг 1 их наяд орчмыг нь БНХАУ, Монголын хамтарсан “Ху Еэ” гэж компани нийлүүлэхээр 200 гаруй тэрбум төгрөгийг нь “Моннис Майс ап” гэж компани “Моннис”-ийн охин компани нийлүүлэхээр ийм тендерт нь сонгон шалгаруулсан. Бид үүнийг цуцлаагүй ээ. Тэр “Ху Еэ интернэйшнл” гэдэг компанийн нийлүүлэх тоног төхөөрөмжүүд хил дээр орж ирснийг нь бид орж ирснийг нь хүлээж авах гэж үзсэн. Олборлолтоо өөрсдөө хийх гэж үзсэн. Шаардлага хангаагүй. Энийг нь бас хууль хяналтын байгууллага шалгасан. Бид шаардлагаа хангаад өгөх юм бол авахад бэлэн гэдэг байр сууриа хэлсэн. Одоо компани тэр компани бол манай шаардлагаа өөрсдөө биелүүлээд техникээ хүлээж аваач гэсэн бид өнгөрсөн 7 хоногт ажлын хэсэг томилоод газар дээр нь үзүүлээд, дахиад шаардлага хангаж байгаа юмнуудыг нь зарим юмнуудыг нь дахиад тогтооё гэж байгаа. Энэ нь ингэх юм бол энэ тендерүүдийг зарлахдаа өөрийн техникүүдийг 30 хувийн олборлолтоо өөрсдөө хийнэ гэдэг байдлаар ингэж зарласан юм байна лээ. Энэ бол хэвээрээ үргэлжлээд явж байгаа. Яг тэр тендер зарласан шаардлагуудыг нь биелүүлээд тоног төхөөрөмжийг нь эхнээсээ хүлээгээд авч хийгдэх ажил ойрын үед хийгдэнэ. Ингэх юм бол олборлолтоо өөрсдөө хийгээд явна гэдэг энэ байдал бол хэвээрээ явж байгаа. Энийг зогсоосон юм байхгүй ээ.

Лицензийн талбайд бол “Энержи Ресурс”-т газар өгөх асуудлыг бид өгөөгүй ээ. Би 1 асуудлыг л “Тавантолгой” дээр очсон хойноо ярьж байгаа юм. Энэ газрыг нь Өмнөговь аймгийн Цогтцэций гэдэг сумаас олгочихдог юм байна. Манайд лицензтэй талбай дээр хувийн хэвшилийн энэ талбайнууд нь жиижиг Таван толгой

байна, Энержи Ресурс байна, бусад компаниуд байна. Би энэтэй холбогдуулан зарим нэг тэр газар олгосон албан тушаалтнуудыг Авлигатай тэмцэх газарт өгсөн.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг 1 минутаар сунгая.

Ж.Ганбат: Яагаад ийм талбай дээр газрын зөвшөөрөл өгөхдөө ингээд компанид мэдэгдэхгүйгээр өгдөг юм бэ гэдэг асуудлыг тавьж байгаа. Өмнөговьтой. Би Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг дарга, Өмнөговь аймгийн Засаг дарга нарт албан ёсоор хэлж байгаа. Та нар ингээд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд газрыг нь өгчихдөг. Үүнээс болоод маргаан үүсэж байна. Одоо бид орон нутгийн жишжиг Тавантолгой дээр тэр овоолго үүсгэчихсэн Энержи Ресурс доод талд нь байгаа. Бид талбай чөлөөл гэдэг шаардлага тавьж байгаа. Тэгэхээр нөгөө газрын асуудлууд нь үүсэж байгаа. Тэд нар өөрсдөө овоолго үүсгэх талбайгүй юм байна лээ. Тэгээд манай лицензтэй талбай руу ингээд орж ирж байгаа. Тэр зөвшөөрлийг нь бол Өмнөговь аймгийнхан ингэж бий болгосон асуудал байна. Заримыг нь хууль хяналтын байгууллагад өгсөн юм байгаа.

Бид бол тээвэрлэлтийг хил нөхцөлөөр өмнө нь ингээд дандаа ам нөхцөлтэй гэрээ ингээд тээврийг бол хятадууд л хийдэг байсан. Ам нөхцөл дээр өөрсдийн тээврээр орж ирээд л аваад явдаг байсан. Хятадуудын тээврийг Монголчууд зарим нь хийдэг, Хятад компанийн жолооч нар хийдэг. Бид.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн микрофоныг нэмээд өгье. 1 минутаар.

Ж.Ганбат: Бид бол уг нь аль болох Монгол тээврийн жолооч нарыг биржийн арилжааны арилжсан нүүрсийг зөөхөд түлхүү оруулж байгаа. Нээлттэй сонгон шалгаруулалтын байдал. Бид уг нь

Монгол жолооч нараа оруулахын тулд олон машинтай тэр Хятад компаниудыг тендерт Монгол жолооч нарт боломж олгохын тулд ингээд 10/21/50 гэдэг багцыг үүсгээд хэсэг хэсгээрээ нийлээд ороод явж байгаа юмнууд бол байгаа. Тэр ам нөхцөлтэй хуучин 4 том компанийн тээвэрт явж байсан компанийн асуудлууд бол Хятадууд өөрсдөө тээврийн зардлыг нь бууруулчихсан юм байна лээ. 110 байж байгаад 80 болгоод, сүүлдээ 60 юань болгоод, энэ асуудлууд дээр юм ярих дээр нь бид нар жолооч нарыг хүлээж аваад тэр худалдан авагч 4 компанитай шаардлагыг нь тавьж байгаад буцаагаад тээврийн зардлыг нь нэмэгдүүлсэн юмнууд байгаа. Энэ дээр уг нь тээвэрчидтэй аль болох л ойлголцоод Монгол тээврийн компаниуд гэж байгаа. Яах вэ одоо “С” зөвшөөрлийг Хятадуудад өгөөд байна гэдэг юм яригдаж байгаа юм. Тэгэхдээ тэр Хятад компаниуд олон гараад байна. Монгол компаниуд гарч чадахгүй байгаа.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Тэгэхээр энэ дээр хамгийн гол зангилаа бол шулуухан хэлэхэд тэр 4 компанийн гэрээ дуусгавар болж байж л энэ асуудал дуусах юм байна лээ шүү дээ. Тэр 4 компани өөрсдөө тээвэрлэлтээ хийж байгаа ам нөхцөлтэй гэрээ. Бид бол хэлэлцээрт орж энэ гэрээний нөхцөлийг өөрчилж гэдэг асуудал тавьсан. Албан ёсоор ЭСЯ-аар дамжуулаад БНХАУ-аас Засгийн газраас та нар өмнө нь байгуулсан гэрээнд хүндэтгэлтэй ханд гэдэг ийм байдлаар асуудал тавьсан учраас ингэсэн. Бид бол энэ “Си” зөвшөөрлийг бид яг л шаардлага хангаж байгаа компаниудад аль болох Монгол тээврийн компаниудаа хамруулахын тулд ил тод, нээлттэй, хувь тэнцүүлээд л олгож байгаа юм. Тэр энэ гэдэг давуу байдал өгсөн юм байхгүй. Яах вэ нөгөө талдаа бид экспорт хийж байгаа компаниудаа

ихэнх нь илүү хийж байгаа гэдэг, тэрийг нь бол анхаарч үзэж байгаа юм байгаа. Нөгөө тал дээр ний нуугүй хэлэхэд зовлон бол байна. Тэр 4 том гэдэг компаниудын асуудал бол нүүрс, хил тээврийн нэвтрэлтээр бүх юм дээр нөлөөлж байна. Татан авалтаар ингэж байна. Бид нар нүүрсийг хүргэлт дээр хүртэл эхэндээ оны эхээр тэр хил нөхцөлтэй Монгол тээврийн .../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон. Тэр боловсон хүчинтэй холбоотой асуудал асуусан байж байгаа. Ганбат дарга тэрийг хариулаад явчих. Хөрс хуулалт гэж байна.

Ж.Ганбат: Боловсон хүчинтэй холбоотой асуудлууд. Би очоод 10 сарын 26-ны өдөр очсон. 10 сарын 26-нд очоод 27-ны өдөр ямар нэгэн баталгаа барьцаагүйгээр 20 гаруй тэрбум төгрөгийг шууд хувийн хэвшлийн тендергүйгээр нууцад хамаарсан компани руу ажлаа хийгээгүй байхад мөнгийг нь өгөх гэсэн үйлдэл гарсан. Түүнтэй холбоотой 5 хүнийг чөлөөлсөн. Мөн санхүүгийн сахилга бат зөрчсөн, асуудал үүссэн, ашиглан хийсэн ийм эмх замбараагүй байдал үүсгэсэн хүмүүсийг би бүгдийг нь чөлөөлсөн. Би зүгээр мөрөөрөө ажлаа хийгээд явж байгаа хүмүүсийг би чөлөөлөөгүй ээ. Энэ дээр би хариуцлагатайгаар хэлнэ. Нөгөө талдаа бид онцгой дэглэмийн үйл ажиллагааны хүрээнд энэ компанийн хэвийн үйл ажиллагааг нь хангахын тулд би 10 сарын 26-нд очоод, саяын хэлдэг 27-нд эхний 20 гаруй тэрбумыг гаргах гэсэн үйлдэл гаргасан ерөнхий нягтлан тэргүүтэй санхүүгийн дарга тэр гол гол яг энэ дээр баримт бичгийг бүрдүүлж гарга гэсэн 5 хүнийг би ажлаас чөлөөлж Авлигатай.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Нэмээд хариулчихъя. Нэгмөсөн дуусгая. Ажлын хэсгийн 5.

Ж.Ганбат: Тэгээд нийтдээ хүмүүс чөлөөлөөд тэгээд хэвийн үйл

ажиллагааг хангахын тулд би оронд нь буцаагаад зарим нэг шаардлагатай хүмүүсийг бол томилсон. Аль болох бид нээлттэй сонгон шалгаруулалтаар хүмүүсийг авахыг бол зорьж байгаа. Энэ ажлыг зохион байгуулаад явж байгаа. Ажлаас халагдсан хүмүүс шүүхэд дандаа хөдөлмөрийн маргаан үүсгэсэн байна лээ. Шүүхийн зарчмаараа яваад зарим нь тэр буцаагаад ав гэсэн хүний шийдвэр бол гараагүй. Бүгдийг нь тэр буруутай нь тэр хүмүүсийн гаргасан үйлдэл нь шүүхээр буруутай нь тогтоогдоод ингээд явж байгаа. Бид шүүх дээрээ буруу зөрүү халсан гэдэг нь тогтоогдоод ав гэх юм бол бид нар авахад бэлэн. Ийм байдлаар явж байгаа.

Хөрс хуулалтын коэффициент ТЭЗҮ дээр заасан яг тэр хэмжээ дээрээ хөрс хуулалтын коэффициент 4,8-аар хэвээрээ явж байгаа. Ямар нэгэн байдлаар бид үйлчилгээний машин, техник хэрэгсэл түрээсэлсэн, сонгон шалгаруулалт хийсэн юм бол байхгүй. Одоо явж байгаа техникүүд дээр яах вэ, сэлбэг авах асуудлыг нь сонгож.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн хариулт хангалттай юу. Ганбаатар гишүүн тодруулъя гэж байна. Ганбаатар гишүүний микрофоныг өгөөрэй.

С.Ганбаатар: Саяын зүйлүүдийг би бас бичгээр асууна. Та нар бичгээр бас надад хариулах байх. Тэгээд хөрс хуулалтын асуудал дээр болон ер нь алтаар өндөглөдөг нугасаа алтыг нь ахиухан авахын тулд алдаг үлгэртэй адилхан Шарын голын нүүрс шиг болчхов л гээд байгаа шүү. Шарын голын нүүрс хөрс хуулалт болон уулын ажлын төлөвлөгөө нь маш буруу явагдаад л тэгээд л одоо үндсэн нөөц дээрээ хамаг шороогоо овоолчихсон. Одоо яахаа мэдэхгүй байгаа. Өнөөдөр ингээд БЭТ томилогдоод ажиллаж байна. 1 жил юм уу, 2 жилийн дараа гэхэд энийг бол яг маркшейдерүүд мэргэисэн хүмүүс нь

хариулах байх. Уулын ажлын ашиглалтынхан нь хариулах байх. 1 жилийн дараа юм уу, одоо ирэх жил гэхэд хасах руу ороод ашигт үйлийн коэффициент нь унаад муудаад ирвэл өнөөдөр хариуцлагаа үүрнэ. Өнөөдөр энэ дээр бас би яг тэр хариуцсан хүмүүсээс нь тодруулж асууя. Хөдөлмөрийн аюулгүй байдал, Байгаль орчин тоосжилтын асуудал ер нь ямар.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсэг 5 дугаар микрофон. Ганбат дарга.

Ж.Ганбат: би эхлээд товчхон хариулчихъя. Би яг тантай санал нэг байгаа. Намайг “Эрдэнэс Тавантолгой” дээр яг очиход уул уурхайн мэргэжлийн хүмүүс Шарын гол шиг юм болж болохгүй шүү гэдгийг удаа дараа хэлж, би яг тэрийг барьж байгаа юм. Гэхдээ та нэг юм анхаар. Бид 3 сард зарласан хөрс хуулалтын 2 багцын тендер одоо хүртэл шүүхээр эцсийн шийд гараагүй. Ингээд л яваад байдаг. Бид нөгөө талдаа нөгөө борлуулалтаа нэмээд байдаг. Хөрс хуулалтын ажил хоцрогдол руу орчих гээд байдаг. Одоо бид ямар асуудал тавьчихаад, дахиад бид нар зарлаж байгаа юм. Би тэр тендерт орсон компаниудыг та нар маргаанаа болиоч л гэдэг юм ярьж байгаа юм. Бид үнэхээр ажлаа хиймээр байна. Тэд нар өмнө нь надаас өмнө бол бид ингээд шүүх дээр явж байгаад авчихдаг байсан юм гэдэг юм ярьсан хүмүүс байгаа шүү дээ. Бид ингээд яваад авна аа, чи харж байгаарай, бид шүүх дээрээ авна. Чи хүлээж бай, бид аваад өгнө гэдэг юм. Одоо би бол тэрийг нь бид ажлаа хиймээр байна гэдэг шаардлагууд юмнуудыг тавиад явж байгаа. Тэгэхээр бид яг таны хэлж байгаа.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Ч.Алтанбагана: иц “Эрдэнэс Тавантолгой” компанийн Уул уурхайн технологийн газрын дарга Алтанбагана

байна. Уул уурхайн мэргэжлээр 18 жил ажиллаж байна. Манай компанийн хувьд А6/20 гээд төлөвлөгөөндөө уулын ажлын 30 сая метр 30 хувь буюу 71 сая уулын цулыг өөрсдийн техникээр хийнэ гэсэн. Энэ жилийн хувьд олборлолтын ажил 3,5 дахин ихэссэн ч гэсэн бид нар ордыг ашиглах ТЭЗҮ-д тусгасан 4,8м3-даа тусган авч явж байна. Хөрс хуулалт, олборлолтын зардлыг болохоор бид нар бусад компаниудын жишиг үнийг судалсны үндсэн дээр үнийг гаргаж ирсэн. Ордын хувьд том орд болохоор тээвэрлэлтийн талын хамгийн уртдаа 9км болдог болохоор олборлолтын өртөг бусдаасаа арай жооохон өндөр харагдаж байгаа. 1км-т ноогдохоороо бол бусад ордуудаас харьцангуй хямд харагдаж байгаа. 9км зайтай.

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн ээ, Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль гэж байгаа. Тэгээд энэ дээр 13.1.2 дээр үндсэндээ нэмэлт хариулт хэлэхээр бол 2 удаа 1, 1 минутаар л ажлын хэсэг хариулт хэлэх юм байна. 1 удаа тодруулж болно. 1 минутаар. Тэгэхээр Ганбаатар гишүүн тодруулаад асууя гэж байгаа учир микрофоныг нь өгье.

С.Ганбаатар: Би ч Оюутолгой, “Эрдэнэс Тавантолгой”, ГОК 3-аар л судалгаагаа хийдэг хүн. Тэгээд олон асуултууд байна. Би бичгээр явуулна. Тэгээд гол минут бага байгаа учраас 1 л юм асууя. Урьд нь БЭГ томилогдохоос ч өмнө тэр 1072 хувьцааны мэдээллийн төв ч билүү нэг юм байнга лайв хийгээд, нэг сайт мэдээлэл өгөөд байдаг. Энэ яагаад алга болчхов. Би 1072 хувьцааны, энэ 2,5 сая хүн шүү дээ. 2,5 сая хувьцаа эзэмшигчдийн өмнөөс өнөөдөр ярьж байгаа. Тэд нарт мэдээлэл өгнө, тэдний өмнөөс болох бүтэхгүй зүйлүүд байвал асууна, тодруулна, үр дүн гаргана. Жишээ нь дараагийн асуулт бол би 2 дахь асуулт бас боломж олдож байна. Хамгийн ашигтай тэр Гашуунсухайт боомтод жолоочгүй тээвэрлэлт нэвтрүүлж байгаа тэр “Смарт Эко

Транс” гэдэг компани, та нар яагаад өөрсдөө хийж болоогүй юм бэ. Энэ бол цэвэр ашиг сонирхлын зөрчил байна гэж би харж байна. Энэ дээр би дэлгэрэнгүй бас бичгээр асуулт асууна. Та нар бас хариулах байх гэж би.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Тэр 1072 хувьцааны төв ажиллаж байгаа. Манай дээр иргэдийг ирсэн хүмүүсийг хүлээж аваад, яг тэр хуучин байсан хаяг нэршилтэйгээ “Эрдэнэс Тавантолгой” компанийн оффис дээр байж байгаа. Энэ дээр хүмүүс иргэдийг хүлээж аваад холбогдох тайлбарыг нь өгөөд утсаар болон биеэр юмнуудыг нь өгөөд, ажиллаад яваад байгаа. Яах вэ энэ асуудлыг бид яг өмнөх байдлаар нь ажиллуулж байгаа. “Смарт эко” гээд тэр Эй Жи Ви гээд жолоочгүй тээвэр, энэ бол манай компанитай хамааралгүй. Энэ бол тэр боомтын хүрээнд яригдсан ийм асуудал юм байна лээ.манайх биш. Бид бол яах вэ “Эрдэнэс Тавантолгой” -н компани өөрсдөө энэ асуудлыг судалж үзэж байгаад ямар нэг тодорхой юм хийгдээгүй яах вэ тэр боомтын сэргэлтийн хүрээнд тэр Эй Жи Ви-ийн хүрээнд тэр “Смарт эко” гэж компани асуудлыг нь хийгээд одоо бол зарим манай нүүрстэр эй жи ви-ээр гарч байгаа юмнууд байгаа шүү дээ.

Т.Энхтүвшин: Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: “Эрдэнэс Тавантолгой” компанийн тайланг сонсож байна. Тэгээд Тайланд орон нутгийн бүтээн байгуулалтад 19,8 тэрбум 2020 оноос хойш, 2021 оноос хойш Хөгжлийн санд 10,9 тэрбум гээд хөрөнгүүд зарцуулжээ. Эд нарыг задалж хэлээч. Яг ямар ямар нүдэнд харагдах бүтээн байгуулалт, хийгдсэн ажлууд юу байна вэ гэдэг дээр.

Компанийн үндсэн үйл ажиллагаа сайжраад ашиг орлого нэмэгдсэн ийм

тайланд дурдагдаж байна. Гэтэл яг хажууд нь байгаа Цогтцэций сумын хувьд байдал хүнд байгаа. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах гэдэг Үндсэн хуулийн заалт зөрчигдөж байна. Тоосжилт маш их байна. Олон хүн тэр сумд ажилгүй байна. Цэцэрлэг, сургуулийн хүрэлцээ хангамж муу байна. 1080 хүүхдийн багтаамжтай сургуульд 2800 хүүхэд явж байх жишээтэй. Цаашидаа өдөр ирэх тусам хүүхдийн тоо нэмэгдэж, цэцэрлэг, сургуулийн хангамж хүрэлцээгүй болж байна. 800 хүүхдийн цэцэрлэгт 1300 хүүхэд стандарт зөрчөөд явж байна.

Мөн нөлөөллийн бүсийн малчдын асуудал бас их яригддаг. Худаг ус, бэлчээр гаргах малчдын эрүүл мэндийн асуудал ялангуяа Цагаановоо багийн нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой зардал. Энэ хүмүүсээс бас тойргийн гишүүний хувьд хүсэлт, өргөдөл гомдол бас ирж байгаа. Эрүүл мэндийн нөхөн олговрыг “Эрдэнэс Тавантолгой” компаниас өгөхгүй байна гэдэг асуудал яригдаж байна.

Мөн шинэ суурьшлын бүсийн хөрөнгө оруулалттай холбоотой “Эрдэнэс Тавантолгой” компаниас ямар ажлуудыг хийж байна вэ гээд товчхондоо орон нутгийн харилцаа, орон нутгийн хүний нөөцийн бодлого, орон нутгаас нийт ажилчдын хэдэн хувь нь ажиллаж байна вэ. Орон нутгийн компаниуд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр ямар ажил хийж байна вэ. Танайд ер нь Цогтцэций сумын харьяатай аж ахуйн нэгж гэрээт ажлуудыг хийж байгаа ажлууд юу байна вэ. Нийт худалдан ав авалтын хэдэн хувь нь орон нутгийн компаниудыг та бүхэн дэмжиж ажиллаж байгаа вэ гэсэн ийм асуудлууд байна.

2-т нь гэвэл усны асуудал. Баяжуулах үйлдвэр ирэх жил ашиглалтад орно гэж байна. Энэ 100 хувь орох гэж байна уу. Хэсэгчлээд зарим блокууд нь орох гэж байна уу.

Тэгээд загийн усны хоолойн ажил дууссан гэж байна. Усыг маш ихээр хэрэглэх болж байна цаашидаа. Тэгэхээр Загийн усны хоолойн нөөц чинь хэд юм. Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээ хэд юм. Хэдэн жил жил цаашидаа энийг ашиглаж явах юм. Мэдээж загийн усны хоолой гүнийн ус учраас тодорхой хугацааны дараа дуусна. Цаашаа усны төслүүдээ юу гэж харж байна вэ. Цаашаа нэлээн их хэмжээний усны хэрэгцээ шаардлага бий болно. Нөгөө Хөх морьт төсөл, Орхон төслүүдийг өнгөрсөн хугацаанд танайхаас А-б төлөвлөгөө гээд төлөвлөөд явж байсан. Энэ ажил цаашаа хэрхэн үргэлжлэхээр байна вэ гэсэн ийм зүйлүүд дээр эхлээд тодруулга авъя.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. 2020-2023 онд өгсөн нийт 19,8 тэрбум төгрөгөөр гол нь ийм л юмнууд хийгдсэн юм байна лээ. 13,5 км авто замыг барьж хүлээлгэж өгсөн. Энэ бол ашиглалтад орчихсон байгаа. Цагаан-Овоо багийн нүүсэн иргэдийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэсэн. Цогтцэций сумд 2км орчим зам жижиг цахилгааны ажил гэх мэт ажлыг хийж өгсөн юм байна лээ. Ийм ажлуудыг хийж өгсөн байгаа. Мөн сая 2023 оны төсвийн хууль батлагдсантай холбогдуулан орон нутагт хүрэх хандив тусламжийг орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан олгох гээд хууль батлагдсантай холбогдуулан энэ онд Өмнөговь аймагт 5 тэрбум төгрөг өгсөн байгаа. Үүнээс хамтын ажиллагааныхаа гэрээгээр жилд 3 тэрбум төгрөгийг өгөх ийм гэрээтэй ажилладаг юм байна лээ. Энэ дээр нь өмнөх ковид гэж хэлээд 2 тэрбум төгрөг өгөөгүй, дамжчихсан байсан. Энийг нь нэмээд нийтдээ 5 тэрбум төгрөгийг Өмнөговь аймгийн орон нутгийн хөгжлийн санд хүлээлгэж өгсөн ийм байдлаар бол ажилласан. Өмнөговь аймгийн Цогтцэций сум болон Өмнөговь

аймагтай хамтын ажиллагааны хүрээнд бол цаг үеийн шинж чанартай асуудлуудыг тогтмол шийдвэрлээд ирчихсэн юм байна лээ. Одоо нэг асуудал үүсээд байгаа нь шинэ суурьшлын бүстэй холбоотой нөхөн олговор энэ тэрийг нийт нь олгоод ерөнхийдөө дуусчхаж байгаа юм байна лээ. Одоо нэг асуудал яригдаад байгаа нь тэр эрүүл мэндийн нөхөн төлбөр гэдэг асуудлыг нэлээн хүчтэй тавигдаад байна лээ. Энэ асуудлыг бид Эрүүл мэндийн яам энэ тэрээр дамжуулаад яг үүнийг яг яаж тооцож өгөх ёстой юм гэдгээ чиглэлийг нь аваад, үнэхээр ингэж тооцох нь зөв гэдэг юм өгвөл бид энэ дээр бас тодорхой шийдэл гаргаад явах нь зүйтэй байгаа гэсэн ийм байр суурийг баримталж байгаа.

Нийтдээ орон нутгийн иргэдээс нийт ажилчдын 22 хувь буюу нийтдээ 225 ажилтан бол Өмнөговь аймгаас авч ажиллаж байгаа. Бид ер нь аль болох Өмнөговь аймгаас иргэдийг авах талаар Өмнөговь аймгийн Засаг дарга, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргатай ийм байдлаар ойлголцоод ингээд явж байгаа. Болж өгвөл тэр Өмнөговийн иргэдийг авсан нь компани талдаа бид нар зардал мөнгөний хувьд ч гэсэн илүү ашигтай юм байна лээ. Нөгөө талдаа баяжуулах үйлдвэр ашиглалтад орохтой холбогдуулан тэнд ажиллах ажилчдыг бас Өмнөговь болон тэр хавийн бүс нутгаас хүмүүсийг бас авч ажиллуулах нь зүйтэй юм уу гэдэг ийм байр суурийг баримтлан ажиллаж байгаа.

Шинэ суурьшлын бүсийн хотын ерөнхий төлөвлөгөөг батлуулаад, энэ жил аймаг сумд нь гардуулчихсан ийм байдалтай байгаа. 2023 онд 589,6 сая төгрөгийн оёмол, хэвлэмэл арьсан эдлэл, хүнсний бүтээгдэхүүн, төмөр хийцийн гээд үүнийг бол дотоодын үйлдвэрүүдээ авч ингэж ажилласан. Ерөнхийдөө орон нутагтай хамтарч ажиллах ажиллагаа бол харьцангуй бас хэвийн байнгын

дэмжлэг үзүүлээд ингээд ажиллаад явж байгаа.

Тэр нэг сургуулийн асуудал гээд Цогтцэций сум дээр нэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаад царцаад зогсчихсон нэг барилгын асуудлыг шийдвэрлэж өгөөч гэдэг хүсэлтийг албан ёсоор тавьсан. Энэ оны төсвийн үеэр тэр асуудлыг шийдвэрлэх гэсэн. Тэр бол нэг асуудал. Яг тэр баригдаад зогсчихсон барилга дээр тэр үргэлжлэх боломжгүй юм байна гэдэг мэргэжлийн дүгнэлт гарчихсан. Тэрний хохирлыг яах вэ гэдэг асуудлыг шийд шийдвэрлэсний дараа энэ асуудлыг төсөв дээр тавихгүй бол өмнө нь нэгэнт төсвөөс мөнгө гарчихсан, тэр чинь бараг 2 тэрбум гаруй төгрөг гарчихсан байна лээ. Тэр мөнгийг яах вэ гэдэг асуудлыг шийдэхгүй бол тэр сургуулийн асуудлыг шийдвэрлэхэд маш хүндрэлтэй юм байна лээ. Одоо тэрийг цоо шинээр эхнээс нь барих асуудал яригдахаас өмнөх нь ингээд ашиглахад бол чанарын.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Усны асуудал. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Баяжуулах үйлдвэр ер нь эхний төслөөрөө 30 сая, 10, 10-аар ийм 3 багцын баяжуулах үйлдвэр барина гэдэг ийм төлөвлөлтийн юмнууд хийгдсэн юм байна лээ. Үүний зөвхөн эхнийх нь 10 сая гэдэг. 10 саяынхаа хүрээнд л усыг бол нийтдээ загийн усны төсөл гээд энэ бол ашиглалтад ингээд хүлээж авч байгаа. Энэ бол нөхөн сэргээгдэх нөөц нь 63 литр секундэд гээд байгаа. Баяжуулах хэрэглээ нь 60 орчим хувийг хэрэглэнэ. Мөн эндээс бас Тавантолгойн станцын хэрэглээний асуудал бас яригдаж байгаа. Бид бол Энержи Ресурсийн баяжуулах үйлдвэрийн одоо ажиллаж байгаа хүчин чадлыг өөрийнхөө үйлдвэрт болж өгвөл 10 сая тонноор нь бүрэн хүчин чадлаараа ажилладаг үйлдвэр ашиглалтад оруулаад бид бүрэн ашиглагдах ёстой гэж бодож байгаа. Энэ хэмжээгээрээ бид нэмэлт орлого ч олно. Энержи Ресурсийн үйлдвэр

бол бүрэн хүчин чадлаараа бас тийм тогтмол ажилладаггүй юм байна лээ. Энэтэй холбогдуулан бид аль болох л энэ үйлдвэрийг 10 саяараа явна. Энэ 10 саяынхаа хүрээнд бол загийн усны хоолойн ус болно. Нэмэлтээр дахиад барихад усны асуудал үнэхээр хүндрэлтэй. Бид ер нь цаашид энэ усны асуудлыг ер нь засгийн түвшинд тавьж байж, энэ асуудлыг тэр Хөх морь гэх юм уу, өөр ямар төсөл гэх юм, яаж явах юм. Одоо тэр хавиас дахиж бид нар усны нөөц илрүүлээд ингэнэ гэхэд маш хүндрэлтэй юм байна лээ шүү дээ ер нь. Ус бол бид ер нь цаашидаа яах вэ гэдэг асуудлыг Байгаль орчны яам, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч шийдлээ гаргаад бас арай өөр шийдэл гаргаж явахгүй бол дахиж бид тэр хавиас ус авах боломжгүй юм байна лээ.

Т.Энхтүвшин: Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Усны асуудал дээр бол үнэхээр онцгой анхаарахгүй бол болохгүй байгаа юм. Үнэндээ 5, 10 жилийн дараа бол энэ том төслүүд чинь усгүй болчих гээд байна л даа. Гүний ус бол тодорхой хэмжээтэй. Тодорхой хугацааны дараа дуусна. Тийм учраас гадаргын усыг ашиглах тал дээр та бүхэн санаачилга гаргаж, дараа жилийн төсвүүд дээр юм тавихгүй бол болохгүй байна. Яагаад би тэгж хэлж байгаа юм гэхээр шинэ сэргэлтийн бодлогод чинь Хөх морь төсөл суучихсан. Энэ 2023 онд Хөх морь төсөлтэй холбоотой ямар ч ажил би хийгдсэнгүй гэж ойлгож байгаа. Ер нь ганц ТЭЗҮ хийгдсэн. Дотоодын компаниар хийгдсэнээс өөр зураг төсөв байхгүй ийм байдалтай. Ядаж та бүхэн ирэх жилийнхээ хөрөнгө оруулалтын төсөв төлөвлөгөө дээр зураг төсвийг нь хийлгэх, энэ ажлыг бас тодорхой эхлүүлэх хэмжээний асуудлуудыг тавихгүй бол болохгүй болчихоод байгаа гэсэн ийм зүйлийг 2024 оны төсөв дээр ч иц.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Үг хэлчихлээ. Туваан гишүүн. Туваан гишүүний микрофоныг өгье.

Ц.Туваан: Эрдэнэс Тавантолгойн тайлан сонсож байна. Тэгээд бас хүний хийсэн юмнуудыг бас хийснээр нь хэлэх ёстой. Эндээс бол нэлээн олон дэвшилүүд гарч байгаа. Тэгээд улсын төсөвт ч тэр бусад зүйлүүдэд нэлээн их хөрөнгө оруулалтуудыг бол хийж өгч байгаа. Тэгээд цаашидаа бол мэдээж анхаарч ажиллах зүйлүүд их байгаа. Оффтейк гэрээ дээр яриад байх юм. Энэ оффтейк гэрээ дээр тэгээд нууцаас ил болчихсон гэрээнүүд дээр Ганбат дарга яг өөрийнхөө амаар хэлчих хэрэгтэй байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр гардаг зөвлөлийн 3 гишүүний чинь 2 нь ажлаа хийгээд байж байгаа. Үнэхээр энэ оффтейк гэрээ дээр тийм нүүрсийг одоо юу гэдэг юм тэг, ингэ тийм төсөл гэхихсэн юмнууд яг байна уу. Тэр нууцаас ил гарсан хэсгийг нь та нэг хэлээд өгөөдхөөч. Тэгээд өмнө нь бид нар бас Чалко, Эс Жи эс энэ тэртэй гэрээнүүд хийгээд л, мөнгө аваад л явдаг. Тэгээд л түүгээрээ хэдэн 10 жил өгсөөр байгаад л дуусдаг шүү дээ. Тэгэхээр энэ рүүгээ эргэж ингэж яриад байгааг нь би бас сайн ойлгохгүй байна. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Биржийн арилжаа чинь ер нь тогтворжсон уу. Гадаад дотоодын тодорхой хүндрэлүүд юу байна. Энэ дээр нэг хариулт өгөөдхөөч.

Төмөр замууд чинь яг өнөөдрийн байдлаар ямар нөхцөл байдалтай байна. Холболтын цэгийг бид нар байнга ярьдаг. Ерөнхий сайд очоод л болчихлоо гээд л ингээд л ярьдаг. Яг энэ дээр чинь нөхцөл байдал өнөөдөр ямар байгаа юм бэ. Төмөр замын тээвэр мэдээж хамгийн хямд тээвэр. Тэгтэл одоо бүр хуучин автомашины замын хажуугаар дахиад зам энэ тэр тавьж байгаа асуудлууд байгаа. Тэгэхээр төмөр замын асуудлаа нэг яриадхаач. Энэтэй холбоотойгоор тэр Тавантолгой түли дээр 900 гаруй

тэрбум төгрөг танайхаас ингээд гараад явж байгаа юм байна. Тэгээд Тавантолгой түли чинь ингээд л Төв аймаг, Дундговь, Өмнөговийн замаар том тэрэгнүүд яваад, энэ замыг бол дуусгаж хаясан. Дээрээс нь Төв аймгийн нутаг дэвсгэр дээр авчирч буулгаад орчны бохирдол гэдэг юмыг үүсгэсэн. Тэгэхээр та нар тэр Тавантолгойгоос яваад энэ чинь Зүүнбаянгаар дамжаад Улаанбаатар руу төмөр замаар ороод ирэх боломж байгаа шүү дээ. Энийг ер нь судалж үзсэн юм байна уу. Энэ асуудал дээр ямар байр суурь хэлэх вэ.

Орон нутаг дээр бол энэ жил сая Наранбаатар гишүүн ярьчихлаа. Тэгэхээр тодорхой хариултууд авчихлаа. Энэ жилийн төсөв дээр харин орон нутаг руу мөнгө оруулах юм байна. Арай илүү ахиу хэмжээний. Тэгэхээр ер нь бол алтыг нь аваад, авдрыг нь хаядаг энэ зарчим бол буруу байсан. Тэгэхээр энэ дээр дэвшилт гарах юм байна гэж ингэж ойлгож байна.

Хамгийн сүүлийн асуулт бол 1072 хувьцаа. Энэ яг хувьцаа мөн үү. Яг одоо надад энэ хувьцаа байна уу. Би энэ хувьцаагаа борлуулж болох уу. Хувьцааныхаа ногдол ашгийг би өөрөө мэдээд авч юм уу, хүүхэд рүүгээ ингэж шилжүүлж болох уу. Яг ярихаар хувьцаа мөн ч юм шиг, шийдвэрлэх асуудал байгаа гээд. Заримдаа хүмүүс иргэд бол байгаа гэж бодоод ноогдол ашиг ярьдаг. Тэгээд яг тэр ноогдол ашгаа авах ч юм уу, эсвэл борлуулах энэ тэр гээд яг жинхэнэ бодитой хувьцаа болгоод ярих гэхээр өөр шийдвэр дутуу биш ч юм шиг ийм асуудлууд яригддаг. Тэгэхээр энэ дээр ямар хариултыг та өгөх вэ. Яг мэргэжлийн санхүүгийн хүний хувьд энэ дээр нэг тодорхой хариулт авъя аа.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон. Ганбат дарга хариулах уу.

Ж.Ганбат: Оффтейк гэрээтэй холбоотойгоор би түрүүн энэ гэрээний

нөхцөлүүдийг нь өөрчилж барих гэдэг ийм хэлэлцээрүүдийг хийж байсан. Хэд хэдэн санал тавиад хэлэлцээрт ороод. Тэгээд зарим нэг дээр нь бид жишээ нь 90 хувийн нүүрсээр гэдгийг 70 хувь нүүрсээр гэдэг байдлаар хэлэлцээрийн үр дүн гарсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурал, Засгийн газрын зүгээс бол тухайн үед төлбөрийг нүүрсээр барагдуул гэдэг ийм шийдвэр гарчихсан юм байна лээ. Энэ дагуу гэрээ бол хийгдсэн. Гэрээ байгуулагдах нь мэдээж бодлогын хувьд үнэтэй холбоотой заалт байхгүй шүү дээ. Зүгээр ингээд төлбөрийг нүүрсээр барагдуулъя, дараагийн доод шатдаа бол хэлэлцээр хийх шатдаа үнүүдийг тухайн үедээ хэлэлцээрүүд нь ингээд явагдчихсан. Хэт нэг талд давуу байдал үүсгэсэн ийм нөхцөл байдал хийгдсэн гэрээнүүд бол байгаа. Энэ гэрээг цуцлах юм бол 20 хувийн торгуульд орно гэсэн ийм заалттай гэрээ байгаа. Нэгэнт гэрээ бол гэрээ. Ингээд яах вэ бид 20 хувийн торгуультай, тухайн үедээ гэрээний нэг тал болох хувийн хэвшилийнхэн бол өөрсдөө ашигтай байдлаар давуу байдал үүсгээд л гэрээ хийчихсэн ийм нөхцөл байдлууд байгаа.

Биржийн асуудал тогтворжчихсон. Оны эхэнд бол маш хүнд байсан. Одоо бол биржийн арилжаа бид 7 хоног болгон тогтмол 7 хоногт 1-2 арилжаа хийж байгаа. Тогтмол бол хамгийн багадаа 2, дээд тал нь 4, 5 оролцогч бол оролцож байна. Арилжааг хамгийн оргил үедээ 40 хэдэн хүнд дуудаж байгаа. Одоо жишээ нь 1/3 нь сул коксожсон гээд нүүрсийг бид нар 97 доллароос дуудахад 124 доллароор жишээ нь авч байна. Бид нар 150 хэдээс дуудахад 180 хэд дээр авсан. Эрчим хүчний нүүрсийг жишээ нь бид нар 53-аас дуудахад 63, 73 руу авч байгаа гээд биржийн арилжаа бол ингээд тогтворжчихлоо. Одоо ер нь худалдан авагч гаднын компаниуд ч гэсэн биржийн арилжаанд ороод сурчихлаа. Одоо бид нарын гол дараагийн асуудал бол энэ тээвэрлэлтийн асуудал дээрээ л

анхаарах. Тээвэрлэлтийг хүргэж өгөх нөхцөл дээрээ бид хилийн нэвтрэлт дээрээ л бид анхаараад, биржийн нүүрсийг тусгай гарцаар гаргадаг Засгийн газрын шийдвэрийг амжилттай хэрэгжүүлээд ийм гарцтай гарчих юм бол биржийн асуудал бол ингээд цаашидаа ямар нэгэн асуудалгүй явчихна.

Төмөр замын төсөл ТЭЗҮ нь бол Зам, тээврийн хөгжлийн яам дээр энэ холболттой холбоотой асуудал бол Зам, тээврийн яам дээр ТЭЗҮ нь сонгон шалгаруулалт хийгдээд ер нь бол явж байгаа гээд дуусаж байна гэж ингэж ойлгосон. Энэтэй холбогдуулан төмөр зам дээр яг Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгойтой оффтейк гэрээтэй энэ суурь дэд бүтцийнх нь бол 100 хувь орчихсон. Ингээд комисс хүлээгээд авчихсан. Одоо гол юм тэр Бодь хийгээд байгаа 16 зүтгүүр дутуу байгаад байгаа. Энэ 16 зүтгүүрийг хүлээгээд авчих юм бол Бодь компанийн хийсэн ажлууд ингээд бүрэн хийгдчихнэ. Хил холболттой холбоотой ТЭЗҮ нь батлагдах шатдаа явж байгаа. Тэгээд энэ дээр Засгийн газар дээр ажлын хэсэг гарчихсан энэ төмөр замын холболттой ажлууд яригдаад явж байгаа. Энэтэй холбоотой зарим асуудал бас Улсын Их Хурал руу орж ирж байгаа.

1072 хувьцаа бол 2012 онд Улсын Их Хурлын шийдвэр гарсан. Тэгээд энэ дээр бол 2012 оны 4 сараас өмнө төрсөн 2,5 сая иргэд “Эрдэнэс Тавантолгой” компанийн 18,4 хувийг эзэмшиж байгаа. Энэ бол зөвхөн ноогдол ашиг авах зорилттой. Энэ бол хэн нэгэн хүн бусдад шилжүүлдэггүй, арилжиж болдоггүй ийм байгаа. Энийг 2016 оны өмнө сайн хувьцаа гээд нэг удаагийн хөдөлгөөнд оруулахдаа тэр хувьцааг нь мөнгөжүүлээд заримыг нь авчихсан юм байна лээ. Нэг хэсэг хүмүүс тухайн үедээ бэлэн мөнгөөр аваад, хувьцаагаа жишээ нь зарчихсан. Тэрнээс биш энэ хувьцаа бол арилжих болон ямар нэгэн эдийн засгийн эргэлтэд ордог хувьцаа биш. Зөвхөн ноогдол ашиг, иргэдийн эзэмшилд

байдаг ийм л хувьцаа байгаад байгаа юм.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Туваан гишүүн. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон гүйцээгээд хариулчих.

Ж.Ганбат: Тавантолгой түлштэй холбоотой, мидлингийн тээвэрлэлттэй холбоотой асуудлыг ер нь аль болох бид нар энд автомашинаар тээвэрлэхийг нь хориглоод, ер нь зогсоогоод Тавантолгой түлш бол энийг дан төмөр замаар тээвэрлэх ийм байдлаар зохион байгуулж байгаа. Ер нь Зам, тээврийн яамнаас ч ийм асуудал яригдаж байгаа. Сая Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд Өмнөговь, Дундговь аймгуудаар явахад энэ асуудлууд яригдаад, замын асуудлыг сайжруулахаар ирэх оны төсөв дээр зам засварын асуудлыг нь шийдэж байгаа юмнууд байгаа. Тэгэхээр энэ асуудлыг ер нь төмөр замаараа тээвэрлээд, машинаар тээвэрлэхгүй явах бүрэн бололцоотой л юм байна лээ. Тэгээд сая ингээд машинаар ер нь эвдрэл гараад байгаа учраас ингээд зогсоо гэдэг шийдвэр гараад, өнгөрсөн жилээс хойш төмөр замаар тээвэрлэгдээд ингээд ажил нь зохион байгуулаад явж байгаа юм.

Т.Энхтүвшин: Туваан гишүүн тодруулъя. Туваан гишүүний микрофоныг өгөөрэй.

Ц.Туваан: Нэмээд нэг зүйл тодруулчихъя. Энэ устай холбоотой асуудал. Энэ дээр бид хэд бас сая ч хэллээ. Дахиж говиос бол ус авах боломжгүй ээ гээд. Энэ бол тодорхой байсан. Тэгэхээр энэ дээр “Эрдэнэс Тавантолгой” компаниас бас тодорхой санал санаачилга гаргаад Хөх морь, Орхон говь гээд энэ төслүүдээ одоо явуулсан нь дээр байх. Тэгээд энэ чиглэлд бас түрүүн Наранбаатар гишүүн асуугаад байсан. Энэ чиглэлдээ яг тодорхой компанийн зүгээс ирэх жилийн төсөв төлөвлөгөөндөө оруулаад

шийдвэрлэхээр тавьсан санхүүжилт байна уу. Бид нар энэ жил харлаа шүү дээ. Үер гээд тээ. Борооны цикл эхэлчихлээ шүү дээ. Тэгэхээр энэ их усаа бид нар бүгдээрээ урсаад үер болох нь болоод ингээд гарчхаж байгаа. Тэгэхээр ядаж энэ зүйлийг бүгдээрээ одоо тэнэг хүн ч ойлгохоор байгаа. Тэгэхээр энэ дээр бодож байгаа юм юу байна.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон. Устай холбоотой асуудал. Ажлын хэсгийн микрофоныг өгөөрэй. 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Ус бол үнэхээр “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьд үнэхээр тулгамдсан асуудал. Загийн усны хоолой гээд энэ төсөл бол амжилттай хэрэгжээд энэ бол зөвхөн баяжуулах үйлдвэрт хэрэглээд л болоо. Эндээс бол уурхай өөрийнхөө хэрэгцээнд ашиглаж чадахгүй юм байна лээ. Усны асуудал дээр 2023 оны төсөв дээр 7 тэрбум төгрөгийн ТЭЗҮ, зураг төсөл гээд байсан. Гэхдээ энэ дээр яг компаниас хамаарахгүйгээр Байгаль орчны яам, мэргэжлийн байгууллагуудаас шийдэл гаргаж өгөх ёстой юм байна лээ засгийн түвшинд. Яг усаа Хөх морь төсөл юм уу, эсвэл энийг хаанаас, яаж шийдвэрлэх вэ гэдгийгээ ингээд авч үз гэдэг. Өмнө нь бол усны асуудлыг бас шийдэх гэж удаа дараа оролдож байсан юм байна лээ. Тэр хөв цөөрөм гээд янз бүрийн борооны усыг ингээд тэнд хадгалах ийм байдлаар хөв цөөрөм гээд ийм нэг төсөл хэрэгжээд энэ бас жоохон буруу зөрүү юм яригдаад, бас хэрэгжилт дээрээ бас жоохон чанарын шаардлага хангана, хангахгүй гэдэг ийм юмнууд яригдаж байсан. Ер нь цаашидаа үүнийг бид.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгөөрэй.

Ж.Бат-Эрдэнэ: Танилцуулга ерөнхийдөө харлаа. Тэгээд уул уурхайн биржийн тухай хууль гарсан. 1 дүгээрт биржийн чинь асуудал ерөнхийдөө

тогтворжоод явчхаж байгаа юм байна. Тийм үү. Болж байна. Тодорхой хэмжээний үр дүн гарч байх шиг байна. 150-аар зарж байсан нүүрс чинь 180 болоод л явчихсан. Энэ чинь уг нь бараг л 100 байсан чинь 180 руу орлоо гэсэн шүү дээ. Тэгэхээр энэ нүүрс ер нь нэг хэсэг нүүрсний чинь үйл ажиллагаанд бас гаднынхан орж ирэхгүй бирж нэг их тогтворжихгүй байна гэсэн. Одоо бол ингээд тогтворжоод явчхаж байгаа юм байна. Хамгийн гол нь тэр тээвэр дээр ер нь яах ёстой юм бэ. Сая би тодорхой ойлгосонгүй. Ерөнхийдөө бол төмөр замаараа тээвэр хийвэл болчих юм гэсэн нэг ийм асуудал яригдаад байна. Сая та нар нэг шинэчлэл хийгээд “С” зөвшөөрлийг өөр дээр авчихсан. “С” зөвшөөрлийн өөр дээрээ авсан. Ер нь сая 3 дугаар улирлын байдлаар энэ чинь 20 сая тонн нүүрс гарчхаад байгаа юм байна шүү дээ танайхаар дамжиж. Тэгэхээр 20 сая тонн нүүрсийг гаргахын тулд цааш цаашидаа нэмэгдэх л байх л даа. Хэдий хэмжээний тээвэр хэрэгтэй юм гэдэг ийм тооцоо байна уу, үгүй юу. Ер нь тэнд чинь 18 орчим мянган машин байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр “С”-ээ яаж өгч байгаа юм. Яг одоо зүгээр чи нэг удаа гарсан, 2 дахь удаа нь энийг гаргая гэж гаргаад байна уу. Эсвэл яг тээврийнхээ менежментийг зөв барьж чадаж байна уу, үгүй юу. Тэгээд 20 саяын чинь ер нь хэдэн машин байж байж эргэлтэд орох юм. Зүгээр миний анхны тооцоогоор наадах чинь бараг л 5 сая дотор байхад 5 мянган машин байхад хангалттай байдаг юм шүү дээ ер нь бол. Тэгээд энэ менежментээ хэр барьж байгаа юм. Зүгээр хүсэлт гаргасанд нь май май гээд өгөөд байгаа юм уу. Энийгээ бас тээвэр чинь яах юм 1 дүгээрт.

2 дугаарт. Биржийн тухай хуулийг чинь дагаад Улсын Их Хурлын тогтоол гарсан. Энэ дээр юу гэсэн гэхээр 1 дүгээрт 1072 хувьцааг эргэлтэд оруул гэсэн үүрэг даалгавар Засгийн газарт өгсөн. 2 дугаарт 1072-ыг эргэлтэд 1 дүгээрт оруулъя. 2 дугаарт иргэдэд өгөх

ноогдол ашгаа олгоё гэсэн шүү дээ. Тэгэхээр өнөөдөр ингээд үйл ажиллагаа нь нэлээн жигдрээд аятайхан болоод явж байгаа юм бол, орлого чинь нэмэгдээд явж байгаа юм бол ноогдол ашгаа хэзээ өгөх бололцоо байна. Энэ дээр тооцоо гарч байна уу, үгүй юу. Энэ жилдээ ноогдол ашиг ер нь иргэд Улсын Их Хурлын тогтоолыг нэлээн харж байгаа, хүлээж байгаа. Ноогдол ашгаа бид нар чинь олон жил ерөөсөө аваагүй. 1 дүгээрт эргэлтэд оруулдаг, больё, өгдөг, барьдаг, худалддаг, наймаалдаг ч байдаг юм уу, ямар ч байсан амьд хувьцаатай больё. 2 дугаарт ноогдол ашгаа хэзээ өгөх юм бэ гэсэн асуудлууд байгаа шүү.

3 дугаарт сая усны асуудал ахиад л яригдлаа. Энэ Орхон гол төсөв чинь нэлээн яригдаж байгаад, зогсчихсон асуудал шүү дээ. Би бас энийг араас нь хараад байдаг юм. Орхон боолт хийж байгаад цаашаагаа татъя гэсэн. Ирээдүйд бид нар Орхон гол руугаа оруулах мөнгө хөрөнгө оруулалтынхаа асуудлуудыг та нар санаачилж гаргаж ирэхгүй бол болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ бүр тодорхой эсвэл ямар хэмжээнд байх юм. Эсвэл хурал дээрээс тодорхой шийдвэр гаргах ёстой байдаг юм уу, яадаг юм. Энэ дээр нэг үр дүнтэй явах хэрэгтэй байх шиг байна.

Нүүрс боловсруулах үйлдвэр яах юм бэ. Одоо нүүрс боловсруулах үйлдвэр 2024 онд гэсэн нэг тоо байж байна. Яг эндээ хөрөнгө оруулалтаа оруулж чадаж байгаа юм уу, үгүй юу. Зүгээр та бүхний ингээд танилцуулга чинь хараад байхад танилцуулгаа хийчихдэг, яг үр дүн дээр дараа нь дахиж орж ирэхдээ тэр хөрөнгө оруулалт нь ч болсонгүй, энэ нь ч болсонгүй. Тэгээд одоо бид нар дахиад төлөвлөсөн асуудал маань зогсчихлоо гээд л ороод ирдэг шүү дээ. Тийм болохоор яг хөрөнгө оруулалтаа энэ нүүрс боловсруулах үйлдвэр рүү оруулж чадаж байгаа юм уу. Устай холбоотой асуудлыг шийдэж байгаа юм уу. 2024 оны дунд гэхэд яг ашиглалтад оруулахаар бүр бизнес төлөвлөгөө чинь гарчихсан юм

уу гэсэн ийм асуултад хариулт өгөөч гэж. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Бирж ерөнхийдөө үйл ажиллагаа нь тогтворжчихоод байна. Оны эхээр эхэлж хэрэгжиж байхад мэдээж хүндрэлтэй байсан. Хүмүүс бол бас янз бүрийн ойлголттой байсан. Одоо бирж бол асуудал байна. Би 7 сарын 1-ээс биржээр арилжаалдаг нүүрснийхээ хэмжээг нэмэгдүүлсэн. Хамгийн дээд тал нь 640 мянган тонныг арилжисж үзсэн. Тэгээд хамгийн багадаа 320 мянга, 480 мянга, 540 мянга, 640 мянга гээд ийм байдлаар бид хийсэн. Тэр дундаас өрсөлдөөнүүд үүссэн. Бирж бол тогтворжсон. Одоо асуудалгүй. Бид бол одоо 7 хоногт ингээд өдөр болгон саяар арилжсан ч худалдан авах хүмүүс бэлэн байна. Манайхыг хэзээ яаж арилжих гэж байна гэдэг хүлээлт худалдан авагч талдаа бол нэлээн үүсчхээд байна. Бид бол энэ дээр өөрсдийнхөө уулын ажлын төлөвлөгөө, тээвэрлэлттэйгээ уялдуулаад явж байгаа. Бирж бол асуудалгүй. Бирж дээр бид нийт биржээр арилжсан нүүрс маань хил нөхцөлд Ганцмод боомтод хүргэж өгөх ёстой. Бид тээвэрлэлт дээрээ л анхаарах ёстой. Тээвэрлэлт дээр бид онцгой анхаараад янз бүрийн байдлаар Зам, тээврийн яамтайгаа ажиллаж байна. Ер нь бид экспорт нэмэгдүүлэх бүх юмны зангилаа бол төмөр замын холболт. Төмөр замын холболтыг бид нар аль болох л богино хугацаанд холбох юм бол тээвэрлэлт бол гацахгүй явах юм байна лээ. Төмөр замын холболт хүртэл бид автомашинаар яаж явах вэ гэхээр одоо бид хүргэлт дээрээ өдөрт зөвхөн 300 машин биржийн нүүрсийг гаргаж байж бид ямар ч байсан зарж байгаа нүүрсээ одоогоор зараад байгаа нүүрсээ бид асуудалгүй хугацаанд нь хүргэж өгөх юм байна гэдэг ийм байдлаар ингэж байгаа юм. Яах вэ, энэ хүрээндээ зорилтоо тавиад бид бол нэлээн шахаад ажиллаж

байгаа. Нөгөө талдаа яах вэ тээвэр дээр бид 2 янзын тээврийн юм яваад байгаа юм. Нэг нь бол нөгөө хуучин 4 том гэрээний ам нөхцөлтэй гэрээ. Тэр тусдаа явж байна. Бид бол биржээр арилжсан 6 сая гаруй тонн нүүрсээ хүргэж өгөх гээд энийг бол бид нар нээлттэй сонгон шалгаруулалт хийгээд бол энэ дээрээ хүргэж өгөх ажлыг зохион байгуулаад явж байгаа. Гэхдээ хил нэвтрэлт дээрээ бид Засгийн газраас шийдвэр гараад биржийн нүүрсний тусгай гарцыг бий болго гэдэг үүрэг өгөгдчихсөн. Энэ дагуу “Эрдэнэс Тавантолгой” компани холбогдох яамдтай хамтраад ажиллаж байна. Энэ тусгай гарцаар ингээд гараад урсаад эхэлбэл биржийн нүүрс дээр бид тээвэрлэлт ямар нэгэн гацаагүй явчихна. Тэгэхээр энэ дээр гайгүй.

“С” зөвшөөрөлтэй холбоотой юмнуудыг бол мэдээж цаанаасаа олгож байгаа асуудлууд нь хэмжээ хязгаартай байгаа. Тэгэхээр хэмжээ хязгаараас манай компанид олгож байгаа 4685 “С” зөвшөөрлийг бид бид хүсэлт гаргасан компаниудад нь өгөөд, ер нь бол “Эрдэнэс Тавантолгой” компани яг одоо гарч байгаа 20 сая тонн нүүрсийг тээвэрлэхэд манай дээр 5-6 мянган автомашин байхад бид үүнийг ямар нэгэн асуудалгүй хүргээд өгчихнө. Гэтэл цаана нь нөгөө нийтдээ манайд танай нүүрсийг тээвэрлэе гээд 12, 13 мянган машин хүсэлт тавиад байдаг. Бид тэрнээс талыг нь л жишээ нь 5-6 мянгыг нь л хэрэгцээтэй. Бид бусдыг нь бол хэрэглэж чадахгүй байгаа учраас “С” зөвшөөрөл олдохгүй байна ингэдэг, тэгдэг гээд янз бүрийн сөрөг юмнууд өөл байна. Ер нь бол сая 3 дугаар улирал дээр бол бүр огцом нэмэгдэж байна. Гол экспорт, гол тээврийг манайх хийж байгаа. Одоо жишээ нь бирж дээр Монгол Улс 7,2 сая тонн нүүрс 9 сарын 30-ны байдлаар арилжсанаас 6 сая тонныг “Эрдэнэс Тавантолгой” дангаараа шүү дээ. Тэгэхээр гол тээвэр манай дээр явж байгаа учраас тээврийн компаниуд манайх руу гол танай тээвэрт оръё гэдэг хүсэлтийг тавьж

байгаа нь бол үнэн. Тэгэхээр бид мэдээж хэмжээ хязгаартай учраас 5-6 мянган машинтай байхад бид тээврийг асуудалгүй явуулах ийм байдлаар тээврээ зохион байгуулж байгаа. Ер нь цаашидаа бол төмөр замын холболтыг л яаралтай хийх.

Ноогдол ашгийн хувьд бол хувьцаа эзэмшигчдийн зүгээс бол шийдвэр гаргасан. Энэ шийдвэр дээр бол онцгой дэглэм тогтоохын өмнө 4,3 их наядын өртэй байсан. Энийг бид нар 2 их наядаар бууруулсан. Дахиад 2 их наядын өр байна. Энэ өр төлбөрийг барагдуулах хэрэгтэй. Нөгөө талдаа бид нар төмөр замын холболт, баяжуулах үйлдвэрүүд гэх мэт.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ганбат даргын микрофоныг нэмээд өгчих. Нэмээд хариулаад дуусгачихъя. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Төмөр замын холболт болон баяжуулах үйлдвэртэй холбоотой энэ төслүүдээ бид яаралтай дуусгах шаардлагатай байгаа. Тэгэхээр мөнгө хэрэгтэй. Энэ төслүүдээ амжилттай дуусгаж чадах юм бол мэдээж манай компанийн болон Монгол Улсын орох орлого нэмэгдэнэ. Тийм учраас бид ноогдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн зүгээс бол түр хойшлуулчихсан байгаа. Ноогдол ашгийг 2019 онд хамгийн оргил ашигтай ажилласныгаа 2020 онд хуваарилсан. Нийт 18,4 хувь буюу 2,5 сая иргэндээ тухайн үедээ 96 мянган төгрөг хуваарилсан юм байна лээ. Нэг иргэнд. Одоо яг үүнийг хуваарилах асуудал нь саяны хэдэн шалтгаанаар ингээд шийдэгдсэн. Ер нь цаашидаа бол ноогдол ашгийн асуудлыг бол яг компанийнхаа зарчмаар компани хуралдаад ашигтай гарсан бол хувьцаа эзэмшигчдээ ноогдол ашгийг нь тараадаг энэ тогтолцоо руу шилжээд явах нь хамгийн зөв юм гэдэг ийм байдлаар хувьцаа эзэмшигчид болон компанийн төлөөлөн удирдах зөвлөл дээр ярилцаад

ийм байдлаар ирэх оноос энэ асуудлыг шийдвэрлээд явна.

Усны асуудлыг хэд хэдэн гишүүд хэлсэн. Үнэхээр “Эрдэнэс Тавантолгой” компани усны асуудал маш хүндрэлтэй. Баяжуулах үйлдвэртэй холбоотой Загийн усны хоолой гээд энэ төсөл бол амжилттай хэрэгжээд, энэ бол зөвхөн баяжуулах үйлдвэртээ л хэрэглэгдэнэ. Цаашид усны асуудлыг яаж шийдвэрлэх вэ гэдэг асуудлыг цогцоор нь шийдмээр юм байна лээ. Ганцхан “Эрдэнэс Тавантолгой” биш, Энержи ресурс, орон нутгийн Тавантолгой гээд тэр бүс нутгийнхан ер нь нийлж байгаад засгийн түвшинд ямар байдлаар энэ дээр усыг хаанаас, яаж хангах юм бэ. Мэдээж газрын гүний ус говь учраас усны хомсдолтой учраас энийг яаж шийдвэрлэх вэ гэдэг бодлого нь яг мэргэжлийн яамдын түвшинд гараад, тэрний дагуу тодорхой болчих юм бол бид төсөв мөнгө дээр нь дэмжлэг үзүүлээд, өөрсдөө хөрөнгө оруулалтаа хийгээд цаашидаа явах бүрэн бололцоотой юм гэж үзэж байгаа.

Ирэх онд боловсруулах угаах үйлдвэр бол 2024 оны 5 сард ашиглалтад орно. Ашиглалтад орох хугацааг нь 2 сараар наашаа татсан. Ийм байдлаар явж байгаа. Ажил бол хэвийн явж байна. Бид аль болох хугацаанд нь оруулахын төлөө ажиллаж байгаа.

Т.Энхтүвшин: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Хэрвээ төмөр зам орсон тохиолдолд бидний авто тээвэргүйгээр зөвхөн төмөр замаараа явж болох бололцоотой юм байна гэснийг сая хэлэх шиг боллоо тийм үү. Энийг нэг тодруулаадахъя.

2 дугаарт холболтоо яах гэж байгаа вэ. Тээврийнхэн болохоор танайхан ч ерөнхийдөө оролцоод байгаа юм шиг яриад байх юм. Танайхан болохоор тээвэр рүү бас ерөнхийдөө

ярьж байгаа. Гол нь Зам, тээврийн яам асуудлуудыг шийдээд явах ёстой л доо. Тэгэхээр чухам зүгээр танай мэдээллээр ямаршуу байна. Тэр хөрөнгө оруулалт нь яах юм, хаанаасаа гарах юм. 2 дугаарт тэр ачиж, буулгах асуудал чинь мэдээж тээврийнхээ асуудлыг тээврийнхээ тухай хуулийн 2 улс хоорондын тээвэрлэлтийнхээ тухай хуулиар цаад талдаа ачиж, буулгах чинь цаад талдаа байх ёстой шүү дээ уг нь бол. Тэгээд тэрийг яг тэр ном дүрмээр нь хийж байгаа юу, үгүй юу. Ер нь яаж төлөвлөж байгаа вэ. Тэгээд хөрөнгө оруулалт. Тэр хөрөнгө оруулалт нь шийдэх юм уу, үгүй юу. 1 дүгээрт холболтын цэг чинь зөв явагдаж байна уу. Тэр улс орнуудын хэлэлцээрүүд чинь зөв явагдаж байна уу. 2 дугаарт холбогдлынхоо цэгт орж байгаа хөрөнгө оруулалт чинь хаанаас гарах юм. Сая өөрөө хэлэхдээ бол эндээс яг.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Ганбат: Төмөр замтай холбоотой ийм байгаад байгаа юм. Ер нь манай нүүрс тээвэр бол ингээд бид 3 байдлаар явах юм байна гэж харж байгаа юм. Нэг нь масс нь бол төмөр зам холбогдохоор төмөр замаар явна. Энэ бол хүчин чадал нь жилд 30 сая, 30-аас дээшээ 70 сая хүртэл гэдэг юмнууд яригддаг юм байна лээ. Энийг Зам, тээврийн яам. Төмөр замаас гадна нөгөө жолоочгүй ухаалаг тээврээс Эй Жи Ви гэдэг асуудал одоо явж байгаа. Энийг бол бид ашиглана. Нөгөө талдаа авто тээвэр гэдэг ийм 3 байдлаар явна. Гол масс нь төмөр замаар явна. Одоо бид төмөр зам холболтгүй ч гэсэн бид нар Тавантолгой төмөр замтай ярьж байгаад төмөр замаар бид тээвэрлээд Гашуунсухайт чингэлэг терминал дээр буулгаад тэрнээс цаашаа машинаар зөөх ажлыг зохион байгуулаад явж байгаа. Тавантолгой төмөр замын хувьд зүтгүүрийн асуудал хүндрэлтэй байгаа учраас бас их хэмжээгээр бидний хүссэн хэмжээгээр тээвэрлэж чадахгүй нөхцөл

байдал байгаа. Тийм учраас бид засгийн түвшинд ярьж байгаад.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ганбат дарга гүйцээгээд хариулчихъя даа.

Ж.Ганбат: Холболтгүй ч гэсэн төмөр замыг ашиглах нь зүйтэй юм гэдэг ийм байр суурь дээр явж байгаа. Төмөр замын холболтын асуудал ТЭЗҮ нь Зам, тээврийн яам дээр зарлагдаад, үүнийгээ дүгнээд, энэ дагуу дараагийн шатын ажил хэлэлцээр гээд Зам, тээврийн яам, Хууль зүйн яам, холбогдох яамнууд ороод 3 ажлын хэсэг гараад, хэлэлцээрийн шатандаа бас юмнууд яваад, зарим холбогдох чиглэлүүд Улсын Их Хуралд өгөхөөр ингэж өргөн баригдаад ингээд ажиллаж байна. Төмөр замыг бол 2 жилийн хугацаанд барьж дуусгана. Хамгийн уртдаа. Тэрнээс аль болох наана. Тэгээд хөрөнгө оруулалтыг нь эхний ээлжид цаад талаасаа гаргана. Бид “Эрдэнэс Тавантолгой” компани нүүрсээр биш мөнгөөр төлбөрийг нь барагдуулах ийм байдлаар ажиллахаар юмнуудаа ярьж байгаа.

Т.Энхтүвшин: Ундрам гишүүн.

Ч.Ундрам: Би энэ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ноогдол ашигтай холбоотой асуудлыг энэ 1072 хувьцаа эзэмшиж байгаа 2,4 сая иргэний төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүний хувиар асуумаар байна. Сая гишүүд асууж байна. Бас хариулт өгч л байна л даа. Тэгэхдээ энд ерөөсөө хангалтгүй хариулт, бас ойлголтын зөрүүтэй юмнууд ч гэсэн яваад байгаа юм шиг санагдаад байна. Бид нар 2023 оны 1 сарын 19-ний өдөр Улсын Их Хурлын 8 дугаар тогтоол гаргасан байгаа. Нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай гээд ийм тогтоол гаргасан. Үүний 2 дугаар зүйл дээр нь Төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах чиглэлээр “Эрдэнэс Тавантолгой”

компанийн хувьцааг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх хүрээнд 2012 оны 4 сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судалж, 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах гэгчихсэн байгаа. Үүний “б”-д нь 2021, 2022 онуудад 1072 ширхэг хувьцааны ногдол ашгаа авч чадаагүй иргэдэд хувьцааны ногдол ашгийг нөхөн олгох асуудлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх гээд энэ 2023 оны 1 сарын 19-нд та бүхэнд үүрэг өгсөн байгаа.

Тэгээд дараа нь 2023 оны 4 сарын 21-ний өдөр Улсын Их Хурлын 28 дугаар тогтоол гарсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг 6 сараар сунгасан. Тэгэхээр 1 сарын та хэдэд өгсөн үүргээ 6 сараар сунгасан байгаад байгаа юм. Тэгээд энэ хугацаа нь энэ сард, 10 сарын 21-нд дуусна. Тийм учраас та бүхэн энд орж ирээд тайлан тавиад сууж байгаа байх гэж би бодоод байна л даа. Тэгээд мэдээж би үгүйсгэхгүй л дээ. Менежментийн хувьд маш олон сайжирсан ажлууд байна. 2023 оны 3 дугаар улиралд цэвэр ашиг 2,7 их наяд төгрөг болсон байна. Ингээд 4 дүгээр улирал дуусахаар бараг чинь 3 их наяд төгрөг гараад явах юм байна гэж ойлгогдож байна.

Хамгийн гол миний асуулт юу вэ гэхээр 2021, 2022 онуудад ноогдол ашгаа авч чадаагүй иргэдэд ноогдол ашгийн нөхөн олгох асуудлыг хууль, тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх гэсэн тогтоол гарсан. Энэ тогтоолыг та хэзээ биелүүлэх юм бэ. Хүүхдүүдэд нөхөж олгох асуудлыг яг яаж шийдэх юм бэ. Тэгээд хувьцаа гэдэг чинь өөрөө хүний өмч шүү дээ. Яг энэ үгийг нь та бид бүгд мэдэж байгаа шүү дээ. 1072 хувьцааг захиран зарцуулдаг, зарж арилжаалдаг ийм байж энийг чинь хувьцаа гэж нэрлэнэ шүү дээ. Тэгэхгүй бол өөр нэр өгөх ёстой юм биш үү. Энийг захиран зарцуулдаг, арилжаалдаг болох тухай

тогтоол 2010 оны 7 сарын 7-нд гарсан байгаа шүү дээ Улсын Их Хурлаар. Тэгсэн чинь та өнөөдөр захиран зарцуулдаг хувьцаа биш, шал өөр юм гээд шал зөрүүтэй юм яриад сууж байна шүү дээ. 2010 оны тогтоол гарснаас хойш 13 жил өнгөрч байна. Энэ ажлыг ерөөсөө хэрэгжүүлэхгүй байна. Яагаад хэрэгжүүлэхгүй байгаад байгаа юм. Хэрвээ Улсын Их Хурал дээр та бүхний асуудлыг хэлэлцээд, ямар нэг тогтоол гараад, тэр чинь хэрэгжихгүй юм бол энд орж ирж ярих ямар шаардлага байгаа юм. Тэр удирдах зөвлөлөөрөө яриад яваач. Яагаад энд орж ирээд яриад байгаа юм. Тэгээд эндээс гарсан тогтоолыг биелүүлэхгүй юм бол тэр тогтоол гаргаж яах юм Байнгын хорооны дарга аа. Тийм биз дээ. Өмнө нь гарсан тогтоолуудаа хэрэгжүүл л дээ.

Т.Энхтүвшин: Үг хэлчих шиг боллоо. Хариулт өгөх юм уу. Энэ удаагийн Байнгын хорооны хурал бол ерөөсөө л энэ онцгой бүрэн эрх тогтоосон хугацаанд хийсэн ажлын тайланг л сонсож байгаа Байнгын хорооны хуралдаан байж байгаа. Ямар нэгэн шийдвэр гарахгүй Байнгын хорооноос. Ажлын хэсэг 5 дугаар микрофон хариулъя.

Ж.Ганбат: “Эрдэнэс Тавантолгой” компанийн 81,5 хувийг нь Эрдэнэс Монгол компани эзэмшиж байгаа. Хувьцаа эзэмшигч. Иргэд бол 2,5 сая иргэд 2012 оны 4 сараас өмнө төрсөн 2,5 сая иргэд 18,44 хувийг нь эзэмшиж байгаа. Нийтдээ 0,06 хувийг нь аж ахуйн нэгжүүд эзэмшиж байгаа гэдэг ийм байдлаар “Эрдэнэс Тавантолгой” -н хувьцааг эзэмшиж байгаа. Энэ хувьцааны талаар 2010 оноос эхлээд Улсын Их Хурлын 39 дүгээр тогтоол 2010 оны 7 сарын 7-нд гараад Монгол Улсын нийт иргэнд эхний ээлжид хувьцааны 20 хувийг адил тэнцүү хэмжээгээр, үнэ төлбөргүй эзэмшүүлэх, хувьцааны 10 хүртэлх хувийг улсын бүртгэлд бүртгэсэн үйл ажиллагаа явуулж байгаа татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд

адил тэнцүү олго гээд 2010 оноос эхлээд яригдаад, 2011 оны 3 сарын 31-нд Засгийн газрын 98 дугаар тогтоолоор 10 хувийг нь 3 дугаар сарын 31-ний өдөр болон түүнээс өмнө төрсөн Монгол Улсын иргэн бүрд “Эрдэнэс Тавантолгой” компанийн 536 ширхэг хувьцааг 1 удаа үнэ төлбөргүй эзэмшүүлэх гээд, 2011 оны 11 сарын 30-нд Улсын Их Хурлын 53 дугаар тогтоол гараад, 2012 оны 4 сарын 11-ний өдрийн Засгийн газрын 116 дугаар тогтоолоор Засгийн газрын 2011 оны 98 дугаар тогтоолын дагуу хувьцаа эзэмшиж байгаа иргэдэд 536 ширхэг хувьцаа нэмж эзэмшүүлэх 2011 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр болон түүнээс өмнө шинээр төрсөн иргэд нь 1072 ширхэг хувьцаа эзэмшүүлэх гээд ингээд шийдвэрлээд, тэгээд 2012 оны 5 сарын 30-нд Засгийн газрын шийдвэрээр 1072 хувьцааг 1 сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 930 төгрөгөөр тогтоосугай гээд ингээд шийдвэрлэчихсэн. Энэ дагуу 2017 оны 5 сарын 30-нд хувьцааг компанийн дүрэмд тусгаж бүртгэх ажил хийгдээд ингээд ийм байдлаар он дараалаар яваад саяын байдлаар ингээд “Эрдэнэс Монгол” компани “Эрдэнэс Тавантолгой”-н 81,50 хувь эзэмших ийм байдлаар шийдвэрлэсэн.

Онцгой дэглэм тогтоох үед 4,3 их наядын өртэй байсан. Энэ асуудлыг өнөөдөр 2 их наядаар өр төлбөрийг нь бууруулсан. Хувьцаа эзэмшигчид “Эрдэнэс Монгол” Засгийн газар дээр онцгой дэглэмээ дуусах хүртэлх хугацаанд өр төлбөрүүдийг цэгцэл, үйл ажиллагааг нь хэвийн болго. Тэр хүртэлх хугацаанд ноогдол ашиг тараах асуудлыг хойшлуул гэдэг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн зүгээс Засгийн газрын шийдвэр гарсан учраас энийг бол хойшлуулчихсан байгаа. 2022 оны жилийн эцэст “Эрдэнэс Тавантолгой” компани 1,2 их наядын ашигтай ажилласан. Үүнийг 2019 оны хамгийн оргил үедээ 2019 онд ашигтай

ажилласныг нь 2020 онд хуваасан юм байна лээ. Тэгэхэд бол 1 иргэнд 96 мянган төгрөг гээд хуваарилж байсан юм байна лээ. Ноогдол ашиг. Дараа нь 2020, 2021 онд ковидын үе гээд бууруулаад, тэрийг нь тооцоод үзэхээр 1 иргэнд 5 мянган төгрөг оногдохоороо юм байна лээ. Энийг нь бид 2022 оны ингээд юун дээр 1,3 их наядаас 18,44 хувийг нь эзэмшиж байгаа 2,5 сая иргэндээ хуваарилахаар 1 иргэнд 115 мянган төгрөг ноогдохоор ийм байна лээ. Тэгэхээр бид хувьцаа эзэмшигчид энэ байдал, тооцоонуудыг хийгээд танилцуулсан. Ийм байна. Өр төлбөрүүд байна. Нөгөө талдаа баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах, төмөр замын холболт гээд бид нар энд ингээд хувьцаа тарааснаас илүү хөрөнгө оруулалтаа нэмээд, өгөөжийг нь өсгөөд, үр ашгийг нь нэмэгдүүлэх чиглэлдээ хөрөнгө оруулалтаа хийгээд, үүний дараа ноогдол ашгийг бол саяын байдлаар.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Ганбаатар гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: “Эрдэнэс Тавантолгой” компанийн онцгой дэглэмийн хугацааны тайланг сонслоо. Улсын төсөвт бас эдийн засаг хүндрэлтэй байх үед урьдчилж зарсан нүүрс гээд бас оруулж ирээд, долларын ханшийг тогтворжуулаад ингээд явахад хамгийн том хувь нэмэр оруулаад явж байгаа компани. Танай менежментийн баг сайн ажиллаж байна. Үр дүн гарч байна. Тэгэхдээ 1 зүйл байгаа юм. Энэ оффтейк гэрээтэй холбоотой асуудал дээр та нар маань ажиллах хэрэгтэй. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, Их Хурлаас хэзээ ч үүнтэй гэрээний үнэ, гэрээний нөхцөлтэй холбоотой шийдвэр гарахгүй шүү дээ. Байгуулах нь зүйтэй юм гэсэн л шийдвэр гарна. Ерөнхий шийдвэр гарна. Тийм биз Ганбат дарга аа, Тэгэхээр энэ гэрээний үнийг, энэ гэрээний төлбөрийн нөхцөлийг, нэг талд давуу байдал олгочихсон энэ

гэрээг хийгээд, энэ компани ямархуу алдагдал өөрөөр хэлбэл ашигт үйлийн боломжит орлогоо алдсан бэ гэдэг тооцооллыг та нар гаргаж ирмээр байна л даа. Яагаад гэвэл энэ нэг их тийм орой биш байгаад байгаа байхгүй юу. Та нар 3 тэрбум төгрөгийн өртөгтэй төмөр замын оффтейк гэдэг 32 хувийн хүүтэй мөнгө зээлчихсэн юм шиг гэрээ шүү дээ энэ чинь ер нь бол мөн тээ? Санхүүгийн ойлголтоор яг тэгж л ойлгогдоно. Тэгэхээр энэ гэрээг байгуулаад 3 тэрбум төгрөгийн, 3 тэрбум долларын өртөгтэй гэрээ байгуулаад, 1,5 тэрбумыг нь олгочихсон байна. Энийг зүгээр л ингээд бүдүүлэг тооцоогоор бодоод үзэхэд одоо бол 480 сая орчим долларын олох боломжоо алдсан байна танай компани. Цаана нь байгаа 1,5 тэрбум доллар, 3 тэрбум долларын гэрээний үнийг нь 1,5 тэрбумыг төллөө гэхэд энэ чинь дахиад тэрбум долларын боломжоо алдана л гэсэн үг шүү дээ. Ер нь 900 гаруй, 960 орчим тэрбум долларын орлого олох, ашиг олох өөрөөр хэлбэл ашиг гэсэн үг шүү дээ. Орлого биш. Боломжоо алдаж байна л гэж харагдаад байгаа юм. Тэгэхээр та бүхэн энэ компанийн менежментийг авч явж байгаа бол бид нар бас нүүрсний сонсгол гээд л, нүүрсний хулгай гээд л нийгэм даяараа шуугьцаалаа. Нэг том эргэлзээтэй цэг нь бол оффтейк гэрээнүүд шүү дээ. Тэгэхээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, Их Хурлаас гарсан шийдвэр бол би дахиад хэлье. Үнэ, нөхцөл ерөөсөө ярихгүй. Тэгэхээр энэ хийсэн гэрээний зөрүү, тэгээд нөхцөл байдлыг нь үнэлгээг нь та нар гаргаад нэг харуулчихмаар байна. Тэгээд үүний араас явах үүрэг бол та нарт байгаа. Компани бол ашигийн төлөө явах ёстой. Өөрийнхөө өмч хөрөнгийн төлөө явах ёстой. Үнэд хүргэхийн төлөө явах ёстой. Үүрэг нь та нарт байгаа. Тэгээд энэ чиглэлээр бас та нар ажиллах хэрэгтэй. Дан ганц тэр төрийн байгууллагуудын шийдвэр рүү чиглүүлээд орхиод байж болохгүй. Тэнд чинь ямар ч тийм ойлголт байхгүй байгаа шүү дээ. Зарчмын шийдэл л гарна.

Энэ дээрээ бас анхаараарай гэж л хүсье дээ. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Компанийн тайлангаас бол тодорхой харагдаж байгаа. Үндсэн үйл ажиллагаа сайжирсан, өр, авлага багасаад, ашиг, орлого нэмэгдсэн ийм үзүүлэлтүүд байна. Бас өнгөрсөн хугацаанд БЭТ томилогдсоноос хойш тодорхой үр дүнд хүрсэн байна гэж би дүгнэж байна. Та бүхнээс хүсэх зүйл бол орон нутгийн хамтын ажиллагаагаа жаахан эргэж харж сайжруулахгүй бол бас үнэхээр та нар чинь өөрсдөө очиж байгаа, харж байгаа. Цогтцэций сум ямар байдалтай байгаа билээ. 2024 оны улсын төсвийн төсөл тарааж өгсөн. Өмнөговь аймагт нэг ч хөрөнгө оруулалт байхгүй. Уул уурхайтай учраас өөрсдөө түүгээрээ аргал гээд ингээд хөрөнгө оруулалт ерөөсөө тавьсангүй. Тийм учраас та бүхэн тэр нутгаас тэр баялгийг нь бас авч байгаа. Монгол Улсын төсөвт Цогтцэций сум бас тодорхой хэмжээний төсвийн орлого төвлөрүүлж байгаа. Тэгээд энэ сумыг хэдүүлээ бас харахгүй бол болохгүй байна. Өнөөдөр хүнд байна шүү дээ. Одоо зөвхөн орон нутгаас гэхэд 200 хэдэн хүн тэнд мэдээж ажиллаж байгаа. Цогтцэций сумд амьдарч байгаа өөр аймгийн хүмүүс ч байгаа. Тэгээд эдгээрийн хүүхдүүд цэцэрлэг, сургуульд бас явах хэрэгтэй болно. Нийгмийн асуудал, боловсролын асуудал, эрүүл мэндийн асуудал мэдээж суманд эмнэлгээр үйлчлүүлж байгаа, боловсролын үйлчилгээ авч байгаа. Тийм учраас сургууль нь өнөөдөр 3 дахин ачаалал нь хэтэрчихсэн. Цэцэрлэг нь бас 2 3 дахин ачаалал нь хэтэрчихсэн. Тэгээд ийм байдалтай байгаад байгаа байхгүй юу. Энэ дээр та бүхэн анхаараад, улсын төсөв дээр юу ч байхгүй юм чинь бас нэг компанийнхаа хөрөнгө оруулалт, ирэх жилийн төсөв төлөвлөгөө дээр бас сумынхаа удирдлагуудтай ярьж байгаад, аймгийн удирдлагуудтай ярьж байгаад

ядаж эхний ээлжид 1 сургуулийн төсөв хөрөнгө тавихгүй бол болохгүй байна. 960 хүүхдийн тэр дутуу сургуулийг та бүхэн анхаарал тавьж байгаад би баяртай байна. Тэгэхдээ энэ чинь бас хугацаа байна. Тэр компани нь ажлаа хаяад явсан. Одоо ингээд шүүхдээж бариад явахаар чинь хугацаа алдана. Нөгөө хүүхдүүд маань дахиад л нөгөө ачаалал нь ихэсчихсэн цэцэрлэг, сургууль байхгүй ийм байдалтай. Ер нь хажуу дахь тосгоноо, сумаа та бүхэн бас харж, өөд нь татаж явахгүй бол тэнд зөвхөн нутгийн уугуул иргэд биш, танай компанийн ажилчид ч тэнд байж байгаа. Өмнө нь бас танайхаас хажууд чинь үйл ажиллагаа явуулж байгаа зарим уурхай бол тодорхой ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдээд сургууль, цэцэрлэгийн асуудлыг нь сумд нь шийдээж өгөөд, ажилчдынхаа орон сууцын асуудлыг шийдээж өгөөд ингээд л явж байгаа жишээ хувийн хэвшилд тодорхой дэргэд чинь байж л байгаа байхгүй юу.

Тийм учраас 100 хувийн хувийн шахуу төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” компани маань бас нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийнхаа хамтын ажиллагааны хүрээнд бас орон нутгийн хүмүүсийг ажил төрөлтэй болгох, орон нутгийн компаниудаас ханган нийлүүлэлт аль болохоор аваад дэмжчих, орон нутагт нь бас сургууль, цэцэрлэг, эмнэлгийнх нь тулсан, тулгамдсан асуудлууд дээр нь тус дэм болох ийм ажлуудыг та бүхэн бас анхаарч цаашидаа төсөв төлөвлөгөөндөө суулгаж ажиллаасай л гэж тойргийн гишүүний хувьд хүсээж байна. Өөр зүйл алга. Амжилт хүсье. Өнгөрсөн хугацааны үйл ажиллагаа бол үнэхээр сайн байна.

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тэгэхээр яах аргагүй ард түмний баялагт нүүрлэчихсэн худал хуурмаг, хулгай зэлгийг арилгах бас нэг зохистой үр

өгөөжтэй байлгах ийм л үүднээс онцгой байдал тогтоогоод л, онц байдал тогтоогоод л, бүрэн эрхтэй төлөөлөгч томилсон. Мэдээж ажлын үр дүн, үндсэн үзүүлэлтүүд, бүх юмнууд сайжирсан. Энийг бид хаа хаанаа бүрэн ойлгох ёстой гэж.

Нэгэнт нөхцөл байдал хэвийн байдал руугаа шилжиж байгаа бол одоо бид тэр хуулийнхаа дагуу явдаг нөхцөлийг нь хангах ёстой. Хуулийн этгээдийн удирдлагууд яаж томилогддог юм. Яаж үйл ажиллагаагаа авч явдаг ёстой юм. Тэр зарчмаараа явах ёстой. Тийм учраас би энэ БЭТ-ийг ер нь тэр компанийг хэвийн үйл ажиллагаа руу нь явуулах, тэр бэлтгэл, зохион байгуулалтыг нь бүрэн хангаж ажиллах ёстой шүү гэдгийг зориуд хэлмээр байна. Би энийг өнөөдрийн Байнгын хорооны хурлаас Засгийн газарт бас чиглэл өгөх хэрэгтэй. Одоо нэгэнтээ үйл ажиллагаа бүх юм тогтворжсон бол энэ хуулийн этгээд яаж удирдлага, үйл ажиллагаагаа томилж авч явдгийг нь яг тэр зарчим руугаа шилжих ёстой гэж нэг ийм зүйл хэлмээр байна.

2 дугаарт ерөөсөө Монголын ард түмний баялаг хөрөнгийг тодорхой бүтээн байгуулалт руу хийсэн бол үр өгөөжийг нь богино хугацаанд гүйцэд хүртэх тэр бололцоог нь бүрдүүлж өгөх ёстой. Тийм учраас энэ их холбогдож өгөхгүй байгаа төмөр зам, тэр тээвэр логистикийн асуудлуудыг маш богино хугацаанд шийдвэрлэж, холбогдох талаар үүрэг чиглэлийг нь өгөх ёстой. Аль цагийн л яриад л байдаг. Хойтон бараг л тэдэн сард л холбочих л юм яриад л ингэцгээгээд л байгаад байдаг. Удаашираад болж өгөхгүй байгаа. Үүнийг бол онцгой анхаарч тэр 2 тал хоорондоо бас тодорхой үүрэг хүлээсэн бол тэр бусдын өмнө хүлээсэн үүргээ хангаж, энэ дээр их тодорхой ажиллах ёстой. Өмнөх хөрштэй тогтоосон харилцаа, хүлээсэн бас тодорхой үүргүүдээ хангаж өгөхгүй удсан тухай асуудал энэ чинь бас бусад Байнгын хороо дээр яригдаад л байгаа

зүйл шүү дээ. Ойлгомжтой. Тийм учраас үүнийгээ хангах ёстой гэж. Энэ нь хангагдаж байж дараа дараагийн хил боомтуудын асуудал, төмөр замын холболтын асуудлууд яригдахаар ингээж яригдсан юм билээ. Тийм учраас энийг шуурхайлах ёстой гэж.

3 дахь зүйл. Аль болохоор бид энэ үр өгөөжийг дээшлүүлэх, ил тод нээлттэй байдлыг хангах тухай л асуудал юм билээ. Тэгэхээр зэрэг ер нь нийт хувьцааны 34-өөс доошгүй хувийг гаргаад хяналтын багц атгаж чадаагүй хүмүүс тэр рүү хөрөнгө хийдэг тэр хувьцааны үнэ цэн өсдөг тухай ойлголт байхгүй юм байна шүү дээ. Энэ чинь ерөөсөө зах зээлийнхээ жаягаар тодорхой хэмжээний үйл ажиллагаанд нь хяналт тавьж чаддаг, бас тодорхой тээг болж чаддаг, бодлого, үйл ажиллагаанд нь оролцож өөрсдийнхөө санал бодлыг шийдүүлж чаддаг эрх олж авахын тулд л тэр хяналтын багцын тухай яригдаад байгаа зүйл юм байна шүү дээ. Тэрэнд нь хүргэлгүй нэг юмнууд гаргачхаад тэгээд төрийн өмчийн үнэ цэнийг унагадаг ч гэдэг юм уу, эс бөгөөс хүртэх ёстой хүмүүст нь үр шимийг нь хүртээж өгөхгүй байгаа ийм зүйлүүд байгаад байгаа байхгүй юу. Энэ ноогдол ашиг чинь яг л ийм байхгүй юу. 18,4 хувийг нь олон түмэн эзэмшиж байгаа. Тэр хүмүүс энэ хүмүүсийн гаргаж байгаа шийдвэрт нөлөө үзүүлэх хэмжээний хувь эзэмшиж чадаагүйтэй холбогдоод өнөөдөр ийм зоргоороо маягтай юм ярьцаагаад яваад байгаа байхгүй юу. Энэ чинь дэлхийн жишиг, зах зээлийн нийгмийн чинь өөрийнх нь үнэт зүйл хүн хөрөнгө юмаа тодорхой баялаг бүтээдэг салбар руу хийчихсэн бол түүний менежментийг сайжруулах, үр өгөөжийг нь дээшлүүлэхэд санал, бодол өөрийнхөө оролцоог хийж чаддаг, гарсан үр өгөөжөөс нь хувиа авч чаддаг, үүнийг чинь л өөрийг нь зах зээлийн нийгмийн чинь үнэт зүйл гэж яриад байна шүү дээ. Тэгж байж энэ компанийн засаглалын сайжралт, үр өгөөжийн дээшлэлт энэ бүх юм чинь явах ёстой юм байна. Тийм

учраас үүнийг бид Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийнхаа асуудлыг маш яаралтай баталж, энэ жосоохон бүдэг хаашаага ч гулгуулж болоод, тайлбар хийгээд болоод байдаг энэ эрх зүйн орчныг нь зөв зохицуулж өгөх тал дээр нь Байнгын хороо анхаарлаа төвлөрүүлж ажиллах шаардлага байна. Уг нь би Ганбатыг Сангийн яамны төрийн нарийн БЭТ-ээр оччихлоо. Энэ хүн Монголын төрийн өмчийг үр өгөөжтэй байлгах, бас үнэ цэн авчрах бололцоо боломжийг нь бүрдүүлэхэд нэлээн том хувь нэмэр оруулж, тэнд ажилласан хугацаанд харагдсан засах задруулах ёстой зүйлүүдээ тодорхой томъёолоод саналуудаа.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Би зарим хүмүүс шиг нялдагадаж, долоож чадахгүй. Бүрэн эрхт төлөөлөгч ажлаа аваад маш муу хийсэн. БЭТ томилогдсон хугацаанд “Эрдэнэс Тавантолгой” компани хууль үйлчилдэггүй вант улс болсон. Би бүгдийг нь баримтаар ярьж байгаа. БНМАУ-ын 1991 оны хууль, Засгийн газрын 2022 оны 362, 85 дугаар тогтоолынхоо хэрэгжилтийг хангаж ажиллаж чадсангүй. Хуулиа л дагадаг байх даа. Тэр хууль дээр юу заасан тэрийгээ л асууна. 500 сая долларын орлого бүрдүүлнэ гэсэн 350 байна. Би шилэн дансаа л дагадаг байх даа. Хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдсан. Ил тод биш болсон. Би баримттай ярья. Би түрүүн асуулт дээр чинь тийм олон юм асуухаар ерөөсөө чадахгүй. Энэ аудитын дүгнэлт дээр “Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072 ширхэг хувьцааны нэрлэсэн үнийн тогтоолыг хийгээгүй, тооцооллыг огт хийгээгүй. Тавантолгойн бүлэг ордын үнэ цэнийг үүнээс болж бууруулсан гээд бичсэн байна. “Эрдэнэс Тавантолгой” компанийн төрийн мэдлийн ногдол ашиг болох 880,2 тэрбум төгрөг Ирээдүйн өв санд төвлөрөөгүй байна. Энэ дээр ингээд

бусдыг нь би дэлгэрүүлж яриад яах вэ. Та нар хараад энэ дээр надад бичгээр хариу өгөөрэй. Би тэртээ тэргүй үүний араас явна. Дээр нь нэмээд түрүүн ус ярьсан Наранбаатар гишүүн. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримталдаг бодлогын зорилтыг хэрэгжүүлэх суурь болох усны асуудлыг бүрэн шийдвэрлээгүй. Уялдаа холбоогүй байдлаас, хэрэгжилтэд оролцогч талуудын ажлын уялдаа холбоогүй байдлаас шалтгаалж нүүрсний салбарт ахиц дэвшил гараагүй байна. Дээр нь нэмээд түрүүн ярьсан тэр хөрс хуулалтын коэффициентын тухай ярьсан. ТЭЗҮ-ийн дагуу хөрсний овоолгыг үүсгээгүйгээс их хэмжээний үргүй зардал гаргах эрсдэлтэй байна. Энэ Цанхийн баруун, зүүн уурхай гээд Цанхийн баруун уурхайн хөрс тээвэрлэх талбай Цагаан овоо гээд энэ олон материалуудыг ярих зав алга. Цагийн ч боломж алга. Уурхайд ашиглах усны эх үүсвэрийг шийдвэрлээгүйгээс нүүрсийг сорчлон олборлож байгаа нь ордын үнэ цэнийг бууруулж насжилтыг богиносгож байна. Биржээр 5,6 сая тонныг зарсан. Сорчилж байгаа. Машиг сорчилж байна. Энэ бол ирээдүйд биднийг маш аюултай байдалд оруулна. Өнөөдөр тэр аудитын дүгнэлтийн 47 дугаар хуудас. Энэ компанид сайн засаглалын зарчим хэрэгжихгүй, зөвхөн том хувьцаа эзэмшигч Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэнэс Монгол компанийн зэрэг шийдвэрээр асуудлууд явж байна. Жижиг хувьцаа эзэмшигчдийн 1072 хувьцаа эзэмшигч 2 сая 500 мянган хүний эрх ашиг хохирсон. Энэ дээр бүр тэгээд бичсэн. 3.9-ийг та нар уншаарай. 3.10 дээр “Эрдэнэс Тавантолгой” компанийг засаглалын хувьд зах зээлийн зарчмаар ажиллуулахгүй, өндөр албан тушаалтнууд, улс төрийн өндөр албан тушаалтнууд, сайд дарга нар нөлөөлж ажиллаж байна гээд. Үнэ цэнийг бууруулж, насжилтыг богиносгон сорчилж ашиглахад хүргэсэн байна. Би баримтгүй цээжээр яриагүй шүү дээ. Түрүүн илтгэл дээр 3 удаа ч байна уу даа ярилаа. 2,7 их наядын татвар төлсөн

гэж хэлсэн. Сайн байна. Үгүй ээ, тэгээд ноогдол ашгийг яагаад өгсөнгүй вэ. Бүгдийг нь Засгийн газарт татварт хамаг юмаа тушаачихсан байна шүү дээ. 1072 хувьцаа эзэмшиж байгаа 2,5 сая хүмүүс маш гомдолтой байна. Үгүй ээ, энэ чинь Засгийн газрын болон Их Хурлаар орж ирсэн тэр бүх үүрэг даалгаврууд БЭТ-д 1072-ыг юм өгөөрэй, хүмүүст юм өгөөрэй. 500 сая доллар оруулна шүү. Авлигагүй болгоно шүү. Энэ 40 их наядын авлига яриад байна. Энгийг нь авлигагүй болгоно шүү гэдэг үүрэг даалгавруудыг өгсөн. Тэрнээс биш энэ үүрэг даалгаврыг яагаад биелүүлээгүй вэ гэдгийг гайхамшигтай гоёор тайлбарлуулах гэж таныг БЭТ болгоогүй. Би хувь хүний юм яриагүй шүү. Хувь хүн надад хамаагүй. Өнөөдөр энэ тэмдгийг ард иргэд зүүлгэнэ гэдэг чинь энийг сайн унш, сайн судал, чин сэтгэлээсээ цагаа зориул, энэтэй холбоотой зүйлүүдийг асууж, тодруулж үр дүнг нэхээрэй л гэж байгаа юм. Миний хамт олон нүүрсний энэ асуудал дээр Монголын ард түмэн тэр чигээрээ харж байгаа. Би боловсон хүчний асуудлыг холбогдох хүмүүст нь.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн үг хэлж дууслаа. Би бас үзэл бодлоо илэрхийлье гэж бод гэж байгаа.

1 дүгээрт нь онцгой дэглэмийн хугацаанд бас “Эрдэнэс Тавантолгой” нэлээн сайн ажилласан. Энгийг хүн болгон мэдэж байгаа. Ер нь бид нар урьд жилүүдэд “Эрдэнэс Тавантолгой” яаж гэрээ байгуулдаг юм, яаж томилгоогоо хийдэг юм, яаж хөрс хуулалтаа хэдэн төгрөгөөр хийлгэдэг гэдэг юмыг мэддэггүй л байсан юм шүү дээ. Харин одоо юу гэдэг юм Монгол Улсын Их Хурлын тогтоол гараад, Засгийн газрын шийдвэрээр онцгой дэглэм тогтоосон учир бүх юм ил тод болсон. Ил тод болсон байж байгаа.

2 дугаарт онцгой дэглэм тогтоосон учир улс төрийн нөлөөлөл багассан. Улс төрийн нөлөөлөл.

3 дахь асуудал бол юу гэдэг юм. Монгол банканд тушаадаг валютын урсгал 4 дахин нэмэгдсэн. 2022 онд тушааж байсан мөнгөнөөс 2023 онд тушаасан мөнгө 4 дахин илүү валютыг тушаасан. Томилгоо нь ил тод болсон. Бүх зүйлүүд нь л ил тод, нээлттэй болсон гэж миний хувьд бодож байгаа. Тийм учраас цаашидаа бид нар ер нь сонгууль ойртож байгаа, Улсын Их Хурлын сонгууль болон орон нутгийн сонгууль ойртож байгаа энэ цаг үед онцгой дэглэмийн хугацааг ч бас сунгаад явах нь илүү их зөв оновчтой байхыг ч үгүйсгэх аргагүй. Хувь хүний байр суурь шүү миний. Ер нь энэ улс төрийн нөлөөллийг л бид нар багасгах, цаашидаа улс төрчдийг төрийн өмчтэй компани руу гараа дүрдэг, санал болгодог, айлган далайлгадаг энэ зүйлийг л бид нар багасгах хэрэгтэй. Тийм учраас цаашидаа бол энийг үргэлжлүүлээд явах нь зөв зүйтэй л гэсэн ийм байр суурийг би илэрхийлэх гэж байгаа юм. Бид эхлүүлсэн юмаа дуусгах хэрэгтэй байна шүү дээ. Онцгой дэглэмийн үед бол маш олон зүйлүүдийг эхлүүлсэн. Баяжуулах болон нүүрс угаах үйлдвэрээ бид нар дуусгах хэрэгтэй байж байна. Төмөр замын холболтоо хийж дуусгах хэрэгтэй байна. Төмөр зам дагасан тээвэр логистикийн бүсүүдээ бид нар тодорхойлж тэрийгээ хийж дуусгах хэрэгтэй байна гээд маш олон зүйлүүд ингээд дутуу байж байгаа. Тийм учраас цаашидаа бид нар энэ онцгой дэглэмийг сунгаад явах, БЭТ нь хэн байх нь хамаагүй шүү дээ. Энэ төрийн өмчтэй компани бол цаашидаа онцгой дэглэмээр ядаж л 2024 оныг дуустал улс төрийн сонгууль гээд хардлага сэрдлэг гардаг. Ер нь улс төрийн сонгуулийг юутай харддаг гэхээр төрийн өмчтэй компаниудтай л харддаг шүү дээ. Төрийн өмчтэй компаниуд улс төрчдийг санхүүжүүлж байна. Улс төрчид төрийн өмчтэй компанид шахаа хийж бизнесээ хийж байна гэдэг ийм л хардлага сэрдлээ явдаг учир энэ онцгой дэглэмийг цаашидаа үргэлжлүүлээд явах нь зөв зүйтэй байх гэж миний хувьд бас бодож байгаа.

Тэгээд удаагийн энэ Байнгын хорооны хуралдаанаар бид Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль гэж байдаг. Дэгийн тухай хуулийн 113.1-д энэ хуульд заасны дагуу эсхүл Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд өөрийн санаачилгаар Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллага болон бусад байгууллагын мэдээллийг хуралдаанаар хэлэлцэж сонсоно л гэж байгаа юм. Ямар нэгэн шийдвэр гаргах юм бол байхгүй. Тийм учраас бас гишүүд маань асуулт асууж, үгээ хэлж дууслаа. Ингээд үгээ хэлж дууслаа гээд тасалчихъя.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны талаар Засгийн газрын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг мөн “Эрдэнэс Тавантолгой”-н бүрэн эрхт төлөөлөгчийн мэдээллийг сонсож дууслаа.

Ажлын хэсэг болон сайдад бас баярласнаа илэрхийлье. Энэ удаагийн хуралдаан үүгээр дууслаа.

12.05 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ